МАНАЙ СОНИНЫ IV УЛИРЛЫН ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА

MMINFO.

19 дэх жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,163.487... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2017.09.14. Пүрэв. №156 (4770) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР



Өдөр +20
Шөнө +10

УЛС ТӨР

Д.ДАВААЛХАМ: КАВАСАКИ ӨВЧНИЙ 20 ТОХИОЛДОЛ МОНГОЛД ИЛЭРСЭН

II нүүрт

ОНЦЛОХ ХУУДАС

ТҮГЭЭХИЙНХЭН

V нүүрт

Дугаарын 60 мөр

## Төсвийн мөнгөөр байшин барихаа л больчих

Б.СЭМҮҮН

Ж.Эрдэнэбатын Засгийн газар огцроод долоо хоног өнгөрөв. Дараачийн Засгийн газрын эзэн тодорхойгүй хэвээр. Арай гэж нэг Ерөнхий сайдаа буулгасан МАН-ынхан дараачийнхаа эрэлд мордов. Хуулийн хугацаагаа дуустал (Засгийн газраа байгуулж чадахгүй 45 хоновол УИХ өөрөө тарна) энэ хэвээрээ манарч ч магадгүй. Сураг сонсох нь ээ, Ж.Эрдэнэбатыгаа “Морь унасан толгойгүй хүн” гэж гоочилсоор байгаад унагасан МАН-ын бүлэг дахиад нэг “тахир дутуу” засаг байгуулах гэж байгаа бололтой. Намын дарга, Ерөнхий сайд хоёроо тусад нь томилно гэх шив. За тэр ч яах вэ, 65 суудалтай нам “лаагаа иднэ үү, луувангаа иднэ үү” маньд падгүй болж байгаа юм биз.

**Үргэлжлэл нь III нүүрт**

ҮЗЭЛ БОДОЛ

# ӨӨРИЙН ТОЛГОЙ ДЭЭРХ ӨВСӨӨ ХАРААЧ, МОНГОЛЧУУД АА



Б.ӨНӨРТОГТОХ

Улс төрийн хүрээнд нэлээд өндөр албан тушаал хашдаг нэгэн эрхэм “заан, баавгай хоёр барилдахад дунд нь байгаа шороо заавал хөдөлдөг. Тэр хоёр эвлэрээд тэврэлдсэн ч тэр шороонд боломж байхгүй. Тиймээс ОХУ, БНХАУ гэх хоёр том гүрний дунд байгаа манай улс тэднийг өсөрхсөн ч, тэврэлдсэн ч адилхан л үр дүнг хүртэнэ. Хоёр том гүрний дундаас холдож чадахгүйгээс хойш хөрш орнуудаа хүндэтгэж, ёс заншил, хууль журамд нь нийцүүлж, улмаар найрсаг харилцаагаа мартах учиргүй” хэмээн ярьж билээ. Энэ бол гашуун боловч үнэн үг аж. Дэлхий дахинд өөрсдийн сүр хүч, эрх мэдлийг харуулж буй хоёр том гүрний дунд оршиж буй хөгжингүй улсын иргэд бидэнд дураар дургиж, дунд чөмгөөрөө жиргэх боломж тэр болгон олдох нь юу л бол. Хөршийн найрсаг харилцаагаа юу юунаас эрхэмлэж, ёстой л Ерөнхийлөгч асан Ц.Элбэгдоржийн гаргасанчлан төвийг сахисан бодлогоор төрөө удирдахаас өөр аргагүй билээ. Гэтэл сүүлийн үед өмнөд хөрштэй холбоотой саар мэдээлэл хэтэрхий ихэсчээ.

**Үргэлжлэл нь III нүүрт**

ОНЦЛОХ МЭДЭЭ

## МАН-ын Бага хурал энэ сарын 25-нд болно

Нэр бүхий 31 гишүүнийхээ хүсэлтээр Засгийн газраа огцруулсан МАН-ынхан өчигдөр Удирдах зөвлөлийн хурлаа хийлээ. Хуралдаан өглөө эрт 11.00 цагт товлогдож, бүтэн өдрийн турш намынхаа байранд хуралдсан юм. Хуралдаанаар намын Бага хурал болон Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний асуудлыг хэлэлцэнэ гэсэн ч энэ өдрийн 15.00 цаг хүртэл хуралдахдаа зөвхөн намын Бага хурлынхаа товыг л зарлалаа. Тодруулбал, МАН-ын Удирдах зөвлөл Бага хурлаа энэ сарын 25-ны өдөр хуралдуулах шийдэлд хүрчээ. Хуралдаанаар шинэ Засгийн газраа хурдан байгуулах, намын дотоод эв нэгдлийг хангах асуудлыг хэлэлцсэн аж. Хуралдаанд Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат, Шадар сайд У.Хүрэлсүх тэргүүтэй Удирдах зөвлөлийн гишүүд оролцсон бөгөөд уур амьсгал харьцангуй зөөлөн байсан гэх мэдээллийг эх сурвалжууд өглөө. Удирдах зөвлөлийн хуралдаанаар намын шинэ дарга болон Ерөнхий сайдын томилгооны талаархи асуудлыг хөндөн яриагүй бөгөөд Бага хурлаа хуралдуулсаны дараа эдгээр асуудлыг ярих шийдэлд хүрчээ.

SKY APARTMENT

ГЕРМАН ЧАНАРЫГ ТАНД МЭДРҮҮЛНЭ

ЦӨӨХӨН БАЙР ҮЛДЛЭЭ



37мкв, 46мкв, 49мкв, 52мкв, 55мкв, 57мкв талбай бүхий 2 өрөө орон сууцнаас сонголтоо хийгээрэй



70мкв, 88мкв талбай бүхий 3-4 өрөө орон сууц ердөө 12ш байгаа тул та амжиж сонголтоо хийгээрэй



Дотроо 2 давхар бүхий Дуплекс загварын орон сууц нь 112мкв, 104мкв, 125мкв бүхий 3 төрлийн сонголттой



Тансаг зэрэглэлийн Пентхаус загвар нь 4-5 өрөөтэй бөгөөд 88мкв, 90мкв, 129мкв бүхий 3 төрлийн сонголттой



ТӨЛБӨРИЙН ТААТАЙ НӨХЦӨЛ
УРЬДЧИЛГАА 10%

Банкуудаар тусгайлан үйлчлүүлж, зээлээ 7 хоногийн дотор шуурхай шийдүүлэх боломж

3Г-аас хэрэгжүүлж буй Ипотекын 8% зээлэнд хамрагдах боломж

Борлуулалтын компанитай 1–2 ЖИЛ хүртэлх хугацааны хүүгүй график тохирох боломж

TDB ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК · ХААН БАНК · ТӨРИЙН БАНК · ГОЛОМТ БАНК · ХАСBANK

ХӨНГӨЛӨЛТ УРАМШУУЛАЛ

ОРОН СУУЦНААС СОНГОЛТОО ХИЙСЭН ЭРХЭМ ТАНД БИД ДООРХ ХӨНГӨЛӨЛТ, УРАМШУУЛЛЫГ ҮЗҮҮЛЭХ БОЛНО

Үүдний өрөөний ХУВЦАСНЫ ШҮҮГЭЭГ бэлэглэнэ.

Урьдчилгаа төлбөрөөс хамааран ҮНИЙН ХӨНГӨЛӨЛТИЙГ эдлэнэ.

Sky Апартментын хаяг: БГД 18-р хороо, Амарсанаагийн гудамж, хуучнаар Од кино театрын баруун талд
facebook.com/TheSkyApartment
УТАС: 88002312, 99009795
Захиалга авах хаяг: Сүхбаатар дүүрэг Улсын драмын театрын хойд талд “УЛААНБААТАР ПРОПЕРТИЗ” ХХК өөрийн байранд
www.skyapartment.mn
УТАС: 96066329, 77009919

**ХААН банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2450.00 | 2464.00 | ФУНТ | 3220.00 | 3299.00 |
| ЕВРО | 2905.00 | 2966.00 | РУБЛЬ | 41.70 | 43.60 |
| ИЕН | 22.09 | 22.58 | ЮАНЬ | 373.00 | 378.50 |

**Худалдаа хөгжлийн банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2446.00 | 2462.00 | ФУНТ | 3218.00 | 3304.00 |
| ЕВРО | 2909.00 | 2304.00 | РУБЛЬ | 41.70 | 44.10 |
| ИЕН | 21.97 | 22.62 | ЮАНЬ | 374.00 | 378.40 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ




## Д.ДАВААЛХАМ: КАВАСАКИ ӨВЧНИЙ 20 ТОХИОЛДОЛ МОНГОЛД ИЛЭРСЭН

Г.ГАНЧИМЭГ

*АШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн Эпидемиологи биостатистикийн тэнхмийн эрхлэгч, анагаах ухааны доктор, дэд профессор Д.Даваалхамаас кавасаки өвчний шинж тэмдэг хэрхэн илэрдэг, Монголд иим өвчний тохиолдол гарсан эсэх, эмчлэгдэх боломжтой эсэхийг тодруулж ярилцлаа.*

**-Кавасаки гэж ямар өвчин бэ. Ямар шинж тэмдгээр илэрдэг юм бол?**

-Кавасаки өвчин нь тав хүртэлх насны хүүхдэд зонхилон тохиолддог. Тэр дундаа 80 хувь нь нэг хүртэлх насны хүүхдэд зонхилон тохиолддог өвчин юм. Энэ өвчний үед халдварт өвчин болон харшлын гаралтай тууралттай их ойролцоо шинж тэмдгүүд илэрдэг учраас ялган оношлоход түвэгтэй байдаг. Өндөр халуурах, бүх биеэр тууралт гарах, нүдний салст улайх, уруул ам хагарч, тууралт гарах, хүзүүний тунгалагийн булчирхай нэг талдаа томорч, маш их өвчтэй, эмзэглэлтэй байх, гар хөлийн арьс гуужих зэрэг шинж тэмдэг илэрнэ. АНУ, Япон дэлхийн хаана ч байсан эдгээр шинж тэмдгээр олон улсын удирдамжийн дагуу л оношилдог юм. Үндсэн зургаан шинж тэмдгээс тав нь илэрсэн тохиолдолд энэ өвчний оношийг шууд тавьж болно. Ямар нэгэн лабораторийн оношлогоо, нэмэлт тоног төхөөрөмж шаардагдахгүй. Тийм учраас манай улсад хот, хөдөө хаана ч байсан оношлох бүрэн боломжтой.

**-Монголд иим өвчний тохиолдол гарсан болов уу?**

-Энэ өвчин Монгол Улсын хэмжээнд одоогоор тав хүртэлх насанд 20 гаруй тохиолдол бүртгэгдээд байгаа. Японы хүүхдийн нэрт эмч Кавасаки 1967 онд анх энэ өвчнийг илрүүлсэн. Тэрбээр тэр цагаас хойш Монголд иим өвчтөн байдаг юм уу үгүй юу, эсвэл байгаад оношилж чаддаггүй юм уу гэх мэтээр мэдээлэл хайсан ч энэ талын мэдээлэл огт байхгүй байхаар нь 2005 онд өөрийн биеэр ирж 21 аймгийн хүүхдийн эмч нарт сургалт хийсэн юм. Бид үргэлжлүүлээд судалгаа хийж байж манайд иим өвчтөн байдаг юм байна гэдэг анхны тохиолдлуудыг илрүүлсэн. Дийлэнх нь өөр оноштой эмчлэгдэж байсан. Харин одоо манай хүүхдийн эмч нар олон төрлийн мэдээллийг интернэтээс авдаг болсон л доо. Тусламж үйлчилгээ харьцангуй сайжирч байгаа тохиолдолд зөвхөн шинж тэмдгээр оношилж болох иим өвчнийг оношлох бүрэн боломжтой.

**-Манай улсын хэмжээнд 20 тохиолдол илэрсэн гэхээр шинэ тутам гарч ирсэн өвчин байх нь. Одоо АШУҮИС-ийн бакалаврын хөтөлбөрт оруулах уу?**

-АШУҮИС-ийн сургалтын хөтөлбөрт маш олон төрлийн түгээмэл тохиолддог өвчнүүдийг бүрэн хамруулдаг. Олон улсад магадлан итгэмжлэгдсэн их сайн хөтөлбөртэй. Тухайлбал, манай сургуулийн хүний их эмч бэлтгэх хөтөлбөрийг Европын холбооноос магадлан итгэмжилсэн. Өөрөөр хэлбэл, бакалаврын хөтөлбөрт дэлхий дээр илэрч байгаа өвчний тохиолдол бүрийг заах албагүй гэсэн үг. Хүний эмч болоод төгсөхөд зайлшгүй мэдсэн байх ёстой мэдлэг, чадварыг өгч гаргаж байгаа. Олон улсын төвшинд ч энэ өвчнийг сургалтын хөтөлбөртөө оруулдаггүй. Зөвхөн Японд л бакалаврын хөтөлбөртөө оруулсан байдаг юм. Ховор тохиолддог өвчин болгоныг сургалтын хөтөлбөрт бүгдийг нь багтаах боломжгүй байдаг учраас төгсөлтийн дараах сургалтаар л заадаг. Өөрөөр хэлбэл, яг энэ өвчинтэй тулгардаг, энэ өвчний оношийг тавих шаардлагатай эмч нарт төгсөлтийн дараах буюу богино хугацааны сургалтаар заавал илүү үр дүнтэй. Эмч нар маань ч ажлын байран дээрээ гараад туршлагатай болчихсон байдаг, мөн илүү нарийн мэргэшсэн байх үед нь энэ мэдээллийг өгөх нь зүйтэй л дээ. Тиймээс энэ нь бакалаврын сургалтын хөтөлбөрт зайлшгүй байх шаардлагатай өвчин биш. Гэхдээ энэ өвчний талаархи мэдээллийг тасралтгүй түгээж, оношлогоог нь сайжруулах, улмаар оношлогдсон тохиолдлуудыг эрт эмчилж, хүндрэл гаргахгүй байхын төлөө бид эмч нарт зориулсан сургалт хийдэг. Энэ жил гурав дахь удаагаа бүх аймаг, дүүргийн хүүхдийн эмч нарт зориулсан сургалтыг өчигдөр зохион байгууллаа. Энэ сургалтад 21 аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн эмч нар, есөн дүүрэг болон нарийн мэргэжлийн эмнэлгүүдийн эмч нар нийлсэн 50 гаруй хүн хамрагдсан. Японы талаас Кавасаки өвчин судлалын үндэсний төв, тэгээд таван их, дээд сургуулиас таван эрдэмтэн ирж бүтэн өдрийн сургалт хийсэн юм.

**-Хувийн эмнэлгүүдээс эмч нар хамрагдсан болов уу?**

-Хувийн эмнэлгийн эмч нар ч хамрагдсан.

**-Кавасаки өвчнийг зөв оношилж, эмчлээгүй тохиолдолд ямар хүндрэл гарах вэ. Ер нь эмчлэгдэх боломжтой юу?**

-Энэ өвчний үед зөв оношилж, зөв эмчлэхгүй бол гардаг гол хүндрэл нь хүүхдийн зүрхний титэм судас үрэвсэх, нарийсах, тэгээд бүлэн үүсч гэнэт нас бардаг. Энэ нь хамгийн аюултай. Онош тогтоогдсоны дараа нэн даруй эмчилгээг хийлгэх ёстой. Ингэж байж эдгэрдэг. Хэрэв өөр онош тавьж, буруу эмчилвэл зүрх, судасны өвчний гаралтай хүндрэл болно. Гэхдээ кавасаки өвчний шинж тэмдэг хурц илэрч, түүнээс хойш 10-20 хоногт шууд хүндэрдэг учраас мэдэхгүй өнгөрнө гэж бараг байхгүй.

**-Энэ өвчний дийлэнх тохиолдол нь хаана бүртгэгдсэн бэ. Магадгүй Японд байх. Тэгээд хаана гэдгийг нь мэдэхгүй юм байна?**

-Өндөр хөгжилтэй орнуудад их тохиолддог. Япон улсад 300 гаруй мянган хүүхэд энэ өвчнөөр өвдөж, оношлогдсон байгаа. Жил бүр 10 гаруй мянган хүүхэд шинээр оношлогддог. Японоос гадна Хятад, Хонконг, Тайвань зэрэг Азийн орнуудад өндөр тархалттай. Мөн АНУ-д ч гэсэн их бүртгэгдэж, оношлогдож эмчлэгддэг. Эдүгээ дэлхий даяар уг өвчний шинэ тохиолдлууд тасралтгүй нэмэгдсээр байгаа төдийгүй өндөр хөгжилтэй орнуудад хүүхдийн зүрх судасны олдмол гажиг, зүрх судасны шалтгаант нас баралтын тэргүүлэх шалтгаан болж байна.

**-Манай улсад илэрсэн кавасаки өвчний 20 гаруй тохиолдлыг хаана оншилсон бэ. Монголд уу, эсвэл гадагшаа явж оношоо олсон юм болов уу?**

-АШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн Эпидемиологи биостатистикийн тэнхим Монголын Кавасакийн өвчин судлалын нийгэмлэг, Япон улсын Кавасакийн өвчин судлалын нийгэмлэгтэй хамтран "Кавасакийн өвчний үндэсний сургалт, судалгаа"-г 2005, 2008 онуудад зохион байгуулан үндэсний судалгааг хийж Монгол Улс дахь кавасаки өвчний анхны тохиолдлуудыг илрүүлэн мэдээлж байлаа. Тэр үеийн судалгаагаар 20 орчим тохиолдлыг тодорхойлсон. Өөрөөр хэлбэл, Монголдоо оношилсон гэсэн үг. Түүнээс хойш 10 орчим жил өнгөрчээ. Харин сүүлийн үед энэ өвчнөө гадагшаа явж эмчлүүлсэн дөрөв, таван тохиолдол гарсан.

ХӨНДӨХ СЭДЭВ

## Шинэ Засгийн газар ОУВС-ийн хөтөлбөрийг зогсоох уу

Б.ЭРХЭС

65 гишүүнээр бүлгээ бүрдүүлсэн МАН-ын Засгийн газар бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлснээс хойш нэг жил гурван сар гаруйн дараа бүрэн бүрэлдэхүүнээрээ огцроод долоо хоногийн хугацаа өнгөрлөө. Сэлэнгэ нутгийн хүү Ж.Эрдэнэбатын тэргүүлсэн Засгийн газар өнгөрсөн нэг жилийн хугацаанд чамгүй ажил хийсэн ч эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлаас гарах эрүүл бодит арга хэмжээг эрэхгүй шууд гаднаас зээл тусламж авахаар санаархсан. Тэр дундаа Олон улсын валютын сангаас зээл тусламж авахыг илүүд үзэж, зургаан сарын хугацаанд тэдэнтэй гэрээ хэлцэл хийсэн байдаг. Зүүний чиглэлийн халамжийг чухалчилдаг нам атлаа мөрийн хөтөлбөрөөсөө татгалзаж, иргэдийн амьдралд дарамт учруулах олон шийдвэрийг тэд Валютын сангаас зээл авахын тулд гаргаж байлаа. Хүүхэд бүрт олгож байсан 20 мянган төгрөгийн тэтгэмжийг хаасан. Ахмадуудын тэтгэврийн насыг нэмж, цалингаас авах шимтгэлийг нэмж байлаа. Мөн иргэдийн хадгаламжийн хүүнээс татвар авах хүндхэн шийдвэрийг ч тэд зээлд хамрагдаж, улсынхаа эдийн засгийг аврахын тулд гаргаж буйгаа мэдэгдэж байв. Ингэснээр долоон төрлийн татвар нэмж, Монголын эдийн засагт гэрэл гэхээс илүүтэй дарамт авч ирж байсныг мартах учиргүй. Сангийн сайд Б.Чойжилсүрэн "Энэ бүхэн ард түмний амьдралыг бодсон, улсын эдийн засгийн төлөө хийсэн шийдвэр. Бүх талаар ярилцаж үзээд үүнээс өөр шийдэл олдоогүй. Та бүхэн дэмжихээс өөр аргагүй. Ард түмэн бүсээ чангалахаас өөр арга алга" хэмээн гуйсаар чуулганы хуралдаанаар зээлд хамрагдах шийдвэрийг дэмжүүлж байсан нь саяхных. Тодруулбал, тавдугаар сарын 24-нд албан ёсоор хэрэгжиж эхэлсэн уг хөтөлбөрийг ОУВС албан ёсоор зогсоожээ. Эхний санхүүжилт хэмээн 38.6 сая ам.долларыг Засгийн газарт өгсөн ч цаашдаа Засгийн газар хэрхэн бүрэлдэхээс шалтгаалж санхүүжилт олгоно хэмээгээд зогсоож орхижээ. Өөрөөр хэлбэл, хэвийн үргэлжилж байсан хөтөлбөр Засгийн газар огцорсон учраас цаашид хэрэгжих боломжгүй болсон гэх. Энэ шалтгааныг төр засгийнхан ихэд нууцалж, зөвхөн Монголбанк, Сангийн сайдын хүрээнд асуудлыг нууцалж буй талаар эх сурвалж дуулгалаа. Бүтэн жил гаруйн хугацаанд дунширж, олон ч хүний аж амьдралаар тоглосон атлаа гэнэтхэн иим шийдвэр гаргасан нь олон ч хүний дургүйцлийг төрүүлж эхлэв бололтой. Монгол Улсын Засгийн газар огцорлоо гээд хэрэгжиж эхэлсэн шийдвэр гэнэт зогсох учиргүй байлтай. Гэтэл энэ бүхэн цаанаа өөр учир шалтгаантай гэдгийг албан бус эх сурвалж дуулгав. Тодруулбал, Сангийн сайд Б.Чойжилсүрэнгийн найз гэх Коши Мат албан тушаал буурсан гэх мэдээлэл байна. Монгол Улсын эдийн засгийг ойлголгүй бодит бус дүгнэлт гаргасан, мөн буруу бодлого хэрэгжүүлсэн. Боломж олгосон Засгийн газар нь Ерөнхийлөгчийн сонгуулиас үүдэн гэрээгээ зөрчиж, хүүхдийн мөнгө тараах гэх мэтээр хуулиа зөрчсөн асуудлаас үүдэн албан тушаал буурсан гэх мэдээлэл ч дэлхийн хэвлэлүүдээр гарч байгаа юм. Нөгөө талаар Монгол Улсын асуудлыг тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан шалтгаан нь ОУВС-ийн дотоод зөрчлөөс үүдэлтэй хэмээн зарим эдийн засагчид үзэж буй бололтой. Таамаг үнэн эсэхийг батлахад эрт байгаа ч дараагийн Засгийн газар хэрхэн бүрдэхээс Монгол Улсын эдийн засаг ихээхэн хамаарах болоод байна. Хэрвээ Валютын санд эрх мэдэл өгөхгүй, эс бөгөөс тэдний хүсч буй зүйлийг хийхгүй сайд гарвал энэ хөтөлбөр албан ёсоор зогсох ч эрсдэл үүсэх бололтой. Ерөөс засгийн эрх мэдлээ гадны нэг санд өгсөн өмнөх Засгийн газрын үйлдлийг хэн ч зөвтгөөгүй. Тэр ч байтугай 5.3 хувиар өсөх чадвартай эдийн засгийг 0.1 хувиар агшсан хэмээн таамаг дэвшүүлсэн асуудал ч дээгүүр яригдаж байгаа гэх. Тиймээс шинэ Засгийн газар өмнөх алдаагаа давтахгүйн тулд асуудлыг эргэн харж, хөтөлбөрийг зогсоох талаар яригдаж байгаа сурагтай. Хатуухан хэлэхэд, энэ хөтөлбөрийг зогсооход ч буруудах зүйл алга.

МЭДЭЭЛЭЛ

## Улсын хэмжээнд 29767 тонн үр тариа хураан аваад байна

2017 онд улсын хэмжээнд 393.6 мянган га-д үр тариа, үүнээс 367.2 мянган га-д буудай, 14.9 мянган га-д төмс, 7.5 мянган га-д хүнсний ногоо, 78.2 мянган га-д тосны ургамал, 28.2 мянган га-д тэжээлийн ургамал, 1.9 мянган га-д эмийн ургамал, нийтдээ 524.3 мянган га-д тариалалт хийсэн.

Ургацын урьдчилсан балансаар 271.8 мянган тонн үр тариа, үүнээс 259.2 мянган тонн буудай, 102.3 мянган тонн төмс, 75.7 мянган тонн хүнсний ногоо, 23.6 мянган тонн тосны ургамал, 47.3 мянган тонн малын тэжээлийн ургамал тус тус хураан авахаар байна. 9 дүгээр сарын 12-ны байдлаар 12.3 мянган га-г ангилан хадаж, нийтдээ 36.0 мянган га-гаас 29.7 мянган тонн үр тариа, 1.3 мянган га-гаас 13.1 мянган тонн төмс, 1.8 мянган га-гаас 19.3 мянган тонн хүнсний ногоо, 2.1 мянган га-гаас 3.4 мянган тонн тэжээлийн ургамал, 2.4 мянган га-гаас 1.1 мянган тонн тосны ургамал тус тус хураан аваад байна.

*(Хураасан талбайн хэмжээг хүснэгтээр үзүүлэв.)*

**УРГАЦ ХУРААЛТЫН МЭДЭЭ**

| № | Тарималын төрөл | Хураах талбай (га) | Хураасан талбай (га) | Хувь | Нэгжийн ургац (цн) | Нийт ургац (тн) |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Үр тариа | 288049 | 36084 | 12.5 | 8.2 | 29767 |
| 2 | Төмс | 11271 | 1315 | 11.7 | 99.7 | 13126 |
| 3 | Хүнсний ногоо | 6944 | 1845 | 26.6 | 104.9 | 19353 |
| 4 | Тэжээл | 43522 | 2188 | 4.85 | 16.3 | 3443 |
| 5 | Тосны ургамал | 46505 | 2420 | 5.2 | 4.62 | 1118 |


## ЦЭЦЭРЛЭГИЙН БАГШ, ТУСЛАХ БАГШ СОНГОН ШАЛГАРУУЛЖ АВНА

**ТАВИГДАХ ШААРДЛАГА:**

- Дипломын дээд болон бакалавраас дээш зэрэгтэй, Сургуулийн өмнөх боловсролын багшийн мэргэжилтэй,
- Мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх
- Багш, удирдах ажилтны ёс зүйн хэм хэмжээг сахих
- Сургалтыг төлөвлөх хэрэгжүүлэх, зохион байгуулах, зурж боловсруулах, ярьж ойлгуулах, сэтгэл хөдлөлөө хянах, ачаалал даах чадвартай байх
- Харилцааны өндөр соёлтой, багаар ажиллах чадвартай, хурдан шаламгай, цагийн менежмент сайтай байх
- Тогтвор суурьшилтай ажиллах хүсэлтэй

**БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ:**

- Сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн өргөдөл
- Дэлгэрэнгүй анкет, 2% цээж зураг /www.mnb.mn сайтын "Бусад" гэсэн хэсэгт буй МҮОНРТ-ийн ажилтны анкетыг бөглөх/
- Боловсролын дипломын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
- Иргэний үнэмлэхний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
- Урьд ажиллаж байсан байгууллага, хувь хүний тодорхойлолт
- Нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар

Сонгон шалгаруулалтад оролцохыг хүсэгчид дээрх материалыг бүрдүүлэн битүүмжилсэн дугтуйд хийж 2017 оны есдүгээр сарын 28-ны өдрийн 17:00 цаг хүртэл хугацаанд доорхи хаягаар ирүүлнэ үү.

**Хаяг: Баянгол дүүрэг, Хувьсгалчдын зам-3,**
**Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевизийн байр**
**Хүний нөөцийн алба Утас: 325802**



MMINFO.

МОНГОЛЫН МЭДЭЭ

*19 дэх жилдээ*

**Ерөнхий эрхлэгч:** С.ГАНТОГОО

**Орлогч эрхлэгч** Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

**Хариуцлагатай нарийн бичгийн дарга:** Э.ЭНХЦЭЦЭГ 90873012

**Ахлах редактор:** Б.ӨНӨРТОГТОХ 88006842

**Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба** Н.ПУНЦАГБОЛД 88096454

**Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба:** Б.ӨНӨРТОГТОХ 88006842

**Гэрэл зургийн алба:** Г.АРГУУЖИН 96017873

**Компьютерийн алба:** Б.ГАНЗОРИГ 99998796

**Маркетинг, зар сурталчилгааны алба:** Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

**Захиалга, борлуулалтын алба:** М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

**Дугаарыг эрхэлсэн** Э.ЭНХЦЭЦЭГ

*Улсын бүртгэлийн дугаар: 907300528*
*Индекс: 100757*

**Редакцийн хаяг:** Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот

"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

# ҮЗЭЛ БОДОЛ

# ӨӨРИЙН ТОЛГОЙ ДЭЭРХ ӨВСӨӨ ХАРААЧ, МОНГОЛЧУУД АА

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Бидний яс маханд манжуудад дарлуулж байсан гашуун түүх байдаг ч тусгаар тогтносон Монгол Улсын ард түмэнд одоогоор тийм дарамт алга. Бид өргөн уудам газар нутагт дураар дургиж, дунд чөмгөөрөө жиргэж байна. Хаа хүссэн газраа нүүдэллэж, хэлэх үгээ хэнээс ч эмээхгүйгээр хэлж буй. Төр засгийн тэргүүнээ өнгө үзэмжээр нь доромжилж, өөрийн хүслээр томилж байгааг эрх чөлөө гэж нэрлэх л байлгүй. Парламентын танхимд байгаа улстөрчдийнхөө буруу үйлдлийг шүүмжлэх боломж, бүр цаашлаад доромжлох, гүтгэх эрх нь ч бидэнд бий. Гэтэл хэсэг бүлэг санаатай, санамсаргүй байдлаар Хятадын ард түмнийг бидний дайсан мэтээр ойлгуулах гэж гүтгэдэг, гүжирддэг болжээ. Ингэж бичлээ гээд би дайсан биш. Урвагч, хулгайч ч биш. Туйлширдаг хэсэг бүлгийн оноодог хятад ч биш. Ерөөсөө монголчууд бид өөрийн толгой дээрх бухлыг хараагүй атлаа өрөөлийн толгой дээрх өвсийг хардаг муухай зантай болчихож. Өөрсдөө алдаа дутагдал гаргаж түүнд нь хариуцлага ярих гэхээр энэ шийдвэр нь монголчуудыг гадуурхсан, доромжилсон шийдвэр гэж үздэг ялихгүй атлаа ямаан омогтой үндэстэн болчихоод байгаа юм.

Үүнийг батлах жишээ хангалттай олон бий. Гадны оронд хулгай хийж, архидан согтуурчихаад баръж хорихоор бараг л гадуурхаж дээрэлхсэн учраас хорилоо гэх. Мөрөөрөө ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй баригдаад ирснээ мөн л бусдын буруу гэж тооцно. Улс орны минь нэр хүнд гарна шүү гэж боддог хүн тэдний дунд ховорхон. Өнөөдөр БНСУ-д маш олон хүн ажиллаж амьдарч байна. Бүр 30 гаруй мянган иргэний ажил амьдрал энэ улстай холбоотой байгаа. Эдүгээгээс 10 жилийн өмнө солонгосчуудын бидэнд хандах хандлага шал өөр байлаа. "Чингисийн Монгол" хэмээн биднийг хүндэлдэг, ажилд авах сонирхол ч их байлаа. Гэтэл өнөөдөр монгол хүнд үйлчлэхгүй гэдэг газар хэтэрхий олон болжээ. Дотуур хувцасны дэлгүүр хүртэл үүдэндээ монголчуудад үйлчлэхгүй гэсэн зар хадчихаад байна, цаана чинь. Энэ нь биднийг гадуурхснаас болоогүй юм. Зөвхөн тэнд үйлчлүүлсэн монголчууд хулгай хийж, худал хэлдэг учраас аргагүйн эрхэнд ийм бичиг тавьж буй хэрэг. Гар утас, дугуй алга болохоор Монголд л жи пи эс нь дуугардаг хэмээн нэгэн солонгос ярьж байсныг өөрийн чихээр ч дуулж, өмнөөс нь чих улайж явлаа. Гадны улс оронд очоод монголчууд хамгийн түрүүнд нэгнээ матдаг. Өс санасан сэтгэлээр эх орон нэгтнээ золионд гаргадаг нь худлаа биш. Амьдарч буй улсынхаа хууль дүрмийг үл ойшоодог, согтуугаар машин жолооддог, хулгай хийдэг, бүр хүн хөнөөсөн тохиолдол ч бий. Нэг хэсэг нь хуульд захирагдаж амьдардаг ч хуулиас гадуур, худал хэлж, хулгай хийдэг нь олон учраас бидний нэр хүнд олон ч улс оронд өдрөөс өдөрт унасаар байгаа юм. Тун саяхан БНХАУ-д ял эдэлж байсан нэгэн эрхэм Монголдоо ирсэн тухай хэвлэлээр мэдээлэл гарч байлаа. Гэтэл тэр нөхөр өөрийгөө ямар ч гэмгүй хэмээн зарлаж, бараг л өмнөд хөршид хилсээр ял эдэлж байгаад ирсэн хэмээн ярьж, олон нийтийн сүлжээгээр мэдээлэл цацсан юм. Нөгөөхийг нь дэвэргэх хүмүүс ч бишгүй олон. Бүр хятадууд биднийг дарамталж, бараг л эх оронч андыг маань алах шахлаа хэмээн хийрхэв. Гэвч начир дээрээ өнөөх "эх оронч" маань тус улсад хулгай хийсэн гэмт хэрэгтэн болж таарсан. Шалгуулах хугацаандаа хүндээр өвдсөн учраас Хуульзүйн сайд, Гадаад хэргийн сайд хоёр бүх талаар гуйж явсаар эх оронд нь авчирсан нь тодорхой болсон юм. Гэтэл өнөөх эр эх орондоо ирчихээд ардын баатар болохоор санаархаж, хөршийнхөө талаар худал гүтгэлэг тараасан нь олонд ил болж байлаа. Тун саяхнаас Эрээн хотын хилээр нэвтэрч буй Монгол Улсын эзэмшилтэй машинуудад хяналт шалгалтаа эрчимжүүлэх болсноо урд хөршөөс зарлав. Мөн нүүрс тээвэрлэж Гашуун сухайтын боомтоор гарч буй машинуудад ч хяналт шалгалт хийхээ мэдэгдсэн. Гэтэл үүнийг нь мөн л эх оронч иргэд маань өлгөж аваад Х.Баттулга гэж хүн Ерөнхийлөгч болсноос үүдэж, урд хөрш бидэнд дургүйцлээ. Муу сайн хятадууд даварч байна гэх мэтээр дуулиан дэгдээсэн. Хамгийн инээдэмтэй нь энэ бүх шалтгаан биднээс л болсон гэдгийг Гадаад хэргийн яамнаас онцолсон юм. Өнөөх л монголчуудын болохгүй бүтэхгүй зан хэрээс хэтэрсэн учраас хяналт шалгалтаа эрчимжүүлсэн хэрэг аж. Тухайлбал, БНХАУ-ын Эрээн хотын хилээр нэвтэрсэн монгол жолооч нар энэ оны эхний долоон сарын байдлаар 20 гаруй мянган зөрчил гаргажээ. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, бүрэн бус тээврийн хэрэгсэлтэй замын хөдөлгөөнд оролцох, осол гаргах гэх мэтээр асуудлыг улам бүр хүндрүүлсэн учраас аргагүйн эрхэнд тэд хяналт шалгалтаа эрчимжүүлэхээс өөр аргагүйд хүрчээ. Цаашлаад, Гашуун сухайтын боомтоор нүүрс тээвэрлэж буй жолооч нар биеэ үнэлэгч тээвэрлэдэг, мөн нүүрс дотроо "мими" гэх хар тамхи тээвэрлэж хилээр гаргадаг зэрэг зөрчил дутагдал гаргах болсон учраас шалгалтаа чангаруулсан хэрэг юм билээ. Урд хөршид очиж биеэ үнэлэх хүсэлтэй бүсгүйчүүдийг хар уутанд боочихоод хилээр гаргаж байсан асуудлыг нэг биш удаа танил маань дуулгаж, зургийг нь хүртэл илгээж байв. Ядарсан жолооч нарын сэргээш болдог "мими" буюу хар тамхины наймаа ч тэнд хэрээс хэтэрсэн тухай олон ч хэвлэл хөндөж буй. Энэ мэтээр бидэнд болохгүй зүйл хэтэрхий их байна. Эх орондоо дураар дургиж байдаг хэнэггүй монгол зангаа бид хилийн дээс алхсан ч гаргадаг учраас тэд дургүйцлээ илэрхийлж буй юм. Энэ нь биднийг үзэн ядсандаа, эс бөгөөс эрхшээлдээ оруулах гэсэндээ хийж буй үйлдэл биш гэдгийг эрхэм эх орончид минь тунгааж үзээрэй. Дахин хэлье, ингэж бичлээ гээд би хятад биш юм шүү.

Дугаарын 60 мөр

## Төсвийн мөнгөөр байшин барихаа л больчих

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Харин дараачийн Засгийн газраас нэг л юм гуйя, дандаа мөнгөнд дургүй хүмүүс нь засагт орох юм гэнэ лээ. Аз болоход...

Угаасаа бодлого нь тодорхойгүй, хаашаа яаж явахаа ч тодорхойлж амжаагүй байгаа шинэ Засгийн газарт ганцхан бодлого санал болгоё. Төсвийн мөнгөөр байшин барихаа л больчих.

2012 онд Н.Алтанхуягийн Засгийн газар байгуулагдаад Монголын хүүхэд нэг бүрийг алгасалгүйгээр сургууль, цэцэрлэгт хамруулъя, бага, дунд боловсролыг үнэ төлбөргүй олгоё гэвэл өмнө байсан дээрээ дахиад 600 цэцэрлэг, 300 гаруй сургууль барих хэрэгтэй. Үүнд нь 1.7 их наяд төгрөг хэрэгтэй гэдэг тооцоог танилцуулж байсан. Үүнээсээ тун цөөхнийг барьсан байх, тэгсхийгээд мөнгө нь ч дууссан. Сая хичээлийн шинэ жил эхлэхэд дахиад л нөгөө сургууль, цэцэрлэгийн барилга дутуу, ор, суудал нь хүрэлцэхгүй гэсэн хэрүүл зарга үргэлжилсэн. Улсын цэцэрлэгт хүүхдээ өгөхийн тулд цэвэрлэгчид нь сая төгрөгийн хахууль өгч байгаа тухай ч сонсогдож л байсан.

2007 онд улсын хэмжээнд 40 мянган хүүхэд шинээр төрсөн, түүнээс хойш энэ тоо жил тутам нэмэгдсээр одоо 100 мянгад хүрээд байгаа. Дахиад арван жил болоход сургууль, цэцэрлэгийн ачаалал одоогийнхоос хоёр дахин нэмэгдэнэ. Гэхдээ тэр дутууг дүүргэж байна гээд төсвийн мөнгөөр байшин барьж л болдоггүй юм шүү. Барина аа л гэвэл тендер зарлана, тендерийн мөнгөний хэдэн хувь нь хэний халаас руу ордгийг олон нийт эрх биш гадарлах болсон. Дөнгөж саяхан Засгийн газрыг хөмрүүлсэн 800 тэрбумаас нэг их хол очихгүй л болов уу.

Тиймээс хэрвээ төсөвт мөнгө байж гэмээн тэр мөнгөөрөө байшин барихын оронд баригдчихаад зарагдахгүй байгаа барилгуудаа түрээсэл. Түрээсэлсэн байшиндаа төрийн байгууллагуудаа, сургууль цэцэрлэгтэйгээ оруул. Баахан мөнгө барилга руу хийж түгжээд жил болгон тодотгол хийгээд явж байснаас хамаагүй үр ашигтай, хямд тусна. Ядаж л төрийн нарийн бичиг, Засаг дарга нар чинь авлигын хэргээр аавын хаалга татаад байхгүй ажлаа тайван хийцгээнэ шүү дээ. Тиймээс төсвийн мөнгөөр байшин барьдаг, төр өөрөө худалдан авагч болдгоо л больчих. Барилга бариад, барьсан барилгаа халаах гэж уурын зуух бариулаад, уурын зуухандаа галч авч, галчийнхаа цалинг бодохын тулд нягтлангийн орон тоо нэмээд байвал төсөв чинь улам л тэлээд, тэрнийх нь дарамт иргэн дээр туссаар л байх болно. Үүн дээр харин Л.Оюун-Эрдэнэ гишүүний хэлсэн ганц үгийг гараа өргөөд дэмжье. Төсвийн мөнгөөр цэцэрлэг, сургууль барихаа зогсоо. Эрхэм гишүүн ч гэсэн хэлсэн, ярьснаа ажил хэрэг болгоорой доо. Энэ Засгийн газрыг огцруулахад өөрийн тань хувь нэмэр их байсан шүү. Тиймээс огцруулахдаа нэг юм яриад, огцруулсан хойноо нэг юм яриад, байгуулах гэж нэг юм яриад, байгуулсан хойноо бас нэг өөр юм яриад байж л болохгүй!

ҮЙЛ ЯВДАЛ

# СОЛОНГОСЧУУД БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЛЭЭ







### Цагаа бас эзнээ олсон тусламж

Юуны түрүүнд БНСУ-ын бизнес эрхлэгчдийн сайн дураараа байгуулсан "Changeless Forever Club"-ийн төлөөлөгчид өнгөрсөн долдугаар сард Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын сургууль, дотуур байрны үйл ажиллагаатай танилцаад нутаг буцсаныг дурьдах хэрэгтэй биз ээ. Бат-Өлзий сумын сургууль гэхэд хэдийгээр шинээр баригдсан, дотроо ариун цэврийн өрөөтэй ч худаггүй байсан учраас сурагчид 00-оо ашиглаж чадахгүй өдийг хүрчээ. Сургуулийн сурагчид төдийгүй дотуур байранд амьдардаг хүүхдүүдийн ариун цэврийн орчин ийн дутагдалтай байсан нь солонгосчуудын анхаарлыг татжээ. Тиймээс тус клубын тэргүүн Лee Жон Чеол гишүүдийнхээ хамтаар энэ сарын 1-нд тус суманд дахин хүрэлцэн ирж, нэн тэргүүнд шаардлагатай байсан худгийн санхүүгийн асуудлыг шийдэж өгсөн байна. Ингэснээр сурагчид боловсон 00 ашиглах боломжтой болжээ. Түүгээр ч барахгүй тэд дотуур байранд амьдарч буй хүүхдүүдэд 200 орчим зөөлөн эдлэл гардуулжээ. Энэхүү үйл ажиллагаанд аймгийн ИТХ-ын дарга Д.Ишдорж оролцсон байна. Тэд анх ирснийхээ дараа нутаг буцангуутаа каргогоор дэвтэр, харандаа, агаарын теннис, бөмбөг, хөгжим гээд хэдийгээр цөөн тоотой ч гэсэн сурагчдад хэрэгцээтэй эд зүйл илгээснийг сургуулийн нээлтийн арга хэмжээний үеэр болсон тэмцээн уралдааны бай болгон өгсөн байна. Тус клубынхан сумын сургуулийн үйл ажиллагаа, сурагчдын сурах орчинг сайжруулах зорилгоор гурван жилийн хугацаатай төсөл хэрэгжүүлэхээр болжээ. Энэ хүрээнд жилдээ тус сургуулийг төгсөж, их дээд сургуульд орсон тав хүртэлх оюутны сургалтын төлбөрийг даахаа ч амлажээ.

### Хариу нэхээгүй тус

БНСУ дахь олон улсын "3630" ротари клубын төлөөлөгчид өнгөрсөн долоо хоногийн сүүлээр ээлжит тусламжаа Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын дунд сургууль, хүн эмнэлэг, Соёлын төв, хоёр цэцэрлэгт гардуулсан байна. Бат-Өлзий сумын эмнэлэгт хамгийн шаардлагатай байгаа рентген аппарат, хоёр цэцэрлэг болон сургуульд 450 орчим цагаан хэрэглэл, Соёлын төвд техник хэрэгсэл хандивлажээ. Бат-Өлзий сумынхан ууланд гарч мод хийж, самар жимс түүдэг учраас бэртэх гэмтэх тохиолдол их байдаг бөгөөд энэ үедээ хот руу ирж рентгенд харуулахаас өөр арга байдаггүй байсан аж. Тэд тусламжаа газар дээр нь очиж хүлээлгэн өгсөн бөгөөд сургууль, цэцэрлэгийн хичээлийн шинэ жил дөнгөж эхэлсэнтэй холбогдуулан 700 гаруй хүүхдэд хичээлийн хэрэглэл бүхий гарын бэлгийг ч мөн гардуулсан байна. Тусламж гардуулах үйл ажиллагаанд УИХ-ын гишүүн, Улаанбаатар дахь Өвөрхангай аймгийн Нутгийн зөвлөлийн дарга С.Чинзориг оролцож, орон нутагт онц шаардлагатай байгаа зүйлсийг өгсөн клубын төлөөлөгчид болон сумын иргэдэд хандан талархал илэрхийлж үг хэлсэн юм. Тус клубынхэн гурван жилийн өмнө мөн эмнэлэгт эхо аппарат, сургуульд компьютер гэхчилэн олон төрлийн хандив өгч байсан аж. Солонгосчууд цаашид ч дахин туслахаа илэрхийлсээр байгаа. Харин тусламжийг хүлээн авсан хүмүүс өгсөн зүйлийг нь зөв, хайр гамтай хэрэглэж, худгаа ажиллуулж, хүүхдүүдээ боловсон ариун цэврийн өрөөгөөр үйлчлүүлэх боломжоор нь бүрэн хангах л үүргийг хүлээх хэрэгтэй болж байна.

Дашрамд дурьдахад, энэхүү цагаа бас эзнээ олсон хариу нэхээгүй тусламжийг Бат-Өлзий сумын Нутгийн зөвлөлийн тэргүүлэгч гишүүн С.Цогт, Т.Аззаяа, "Diamond press" клубын Ерөнхийлөгч С.Гантогоо нар зуучлан зохион байгуулж, орон нутагтаа хүргэж, хувь нэмрээ оруулжээ.





# МЭДЭЭЛЭЛ

## АЛБАДАН ДУУДЛАГА ХУДАЛДАА

Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанаас дараах үл хөдлөх эд хөрөнгө, орон сууц, барилга байгууламжийн АНХНЫ албадан дуудлага худалдааг 2017 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 10 цагт албаны байранд зохион байгуулна. Оролцогчдыг 2017 оны 09 дүгээр сарын 27-ний өдрийн 14.00 - 17.00 цагийн хооронд Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны нэг цэгийн өрөөнд бүртгэнэ. Хугацаа хоцорсон хүсэлтийг хүлээн авах боломжгүйг анхаарна уу.

Бүртгүүлэхдээ дуудлага худалдааны дэнчинг мөнгийг Улаанбаатар банкны 2617001560 тоот дансанд тушааж нэг хувийг авчирна уу. Хаяг: Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороо, Үндсэн хуулийн гудамж-3, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба

Цахим хаяг: http://www.nshga.cd.gov.mn, www.facebook.com/pages/Нийслэлийн-Шийдвэр-Гүйцэтгэх-Алба

| № | Үл хөдлөх эд хөрөнгийн хаяг байршил | Иргэний хуулийн 177 дугаар зүйлийн 177.1-д заасан санал болгох доод үнийг тохиролцсон болон үнэлгээчний тогтоосон зах зээлийн үнийн 70 хувь | Хариуцсан шийдвэр гүйцэтгэгч, утасны дугаар |
|---|---|---|---|
| 1 | Баянгол дүүргийн 5-р хороо, 10-р хороолол 80а байр, 158 тоот 43.12 м.кв талбайтай 2 өрөө орон сууц | 48,440,000 | Э.Ундармаа 89086160 |
| 2 | Баянзүрх дүүрэг 14-р хороо, 14-р хороолол 37-р барилга Сандэй плаза дэлгүүрийн 3089 тоот 4,08 м.кв талбайтай лангуу | 19,992,000 | Т.Ариунболор 89086187 |
| 3 | Баянзүрх дүүрэг 14-р хороо, Энхтайвны өргөн чөлөө 81 байр 26 тоот 63,44 м.кв 3 өрөө орон сууц | 69,720,560 | Б.Ганчимэг 89086167 |
| 4 | Баянзүрх дүүрэг 20-р хороо, Хар усан тохой 306Б 381 м.кв талбайтай хувийн сууц | 186,754,103 | Б.Ганчимэг 89086167 |
| 5 | Баянзүрх дүүрэг 20-р хороо, Хар усан тохой 306А 355 м.кв талбайтай хувийн сууц | 200,431,868 | Б.Ганчимэг 89086167 |
| 6 | Баянзүрх дүүрэг 20-р хороо, Хар усан тохой 306 тоот 1535 м.кв эзэмших эрхийн гэрчилгээтэй газар | 25,100,320 | Б.Ганчимэг 89086167 |
| 7 | Баянзүрх дүүрэг 18-р хороо, 13-р хороолол 38 байр 224 тоот 88,7 м.кв талбайтай 5 өрөө орон сууц | 113,787,685 | Б.Ганчимэг 89086167 |
| 8 | Чингэлтэй дүүрэг 1-р хороо, 35-р байр, 88 тоот 25 м.кв талбайтай 2 өрөө орон сууц | 54,600,000 | Н.Өнөржаргал 89086120 |
| 9 | Хан-Уул дүүрэг 3-р хороо, Үйлдвэр /17061/ Эв нэгдлийн гудамж 22, 22/1 тоот 2730,9 м.кв талбайтай үйлдвэрлэлийн барилга, өргөтгөлийн хамт | 980,700,000 | Б.Мөнгөнцэцэг 89086137 |
| 10 | Хан-Уул дүүргийн 1-р хороо, Үйлдвэр /17041/ ХД-40 байр 8 тоот 18 м.кв талбайтай автозогсоол | 20,531,877 | Ц.Чинтуяа 89086190 |
| 11 | Баянгол дүүргийн 3-р хороо 2-р хороолол, Төмөр замын 71-р байр 116 тоот 40 м.кв талбайтай 3 өрөө орон сууц | 72,128,000 | Г.Алтансувд 89086183 |
| 12 | Баянгол дүүрэг 1-р хороо, Богда-Ар хороолол 24а байр 44 тоот 80,20 м.кв талбайтай 3 өрөө орон сууц | 140,350,000 | Ч.Энхтуяа 89086148 |
| 13 | Хан-уул дүүрэг 10-р хороо, Буянт-Ухаа наадамчдын зам гудамж 204 тоот орон сууцны зориулалттай 3400 м.кв талбайтай дуусаагүй барилга | 1,856,400,000 | Э.Батхишиг 89086139 |
| 14 | Баянзүрх дүүрэг 25-р хороо, 13-р хороолол Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж 83-р байр 31 тоот 88,96 м.кв 3 өрөө орон сууц | 99,635,200 | П.Уранбилэг 89086153 |
| 15 | Баянзүрх дүүрэг 25-р хороо, 13-р хороолол Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж 83-р байр 33 тоот 12,15 м.кв талбайтай автозогсоол | 14,000,000 | П.Уранбилэг 89086153 |
| 16 | Сүхбаатар дүүрэг 8-р хороо, 11-р хороолол 3-р байр 60 тоот 40 м.кв талбайтай 3 өрөө орон сууц | 71,680,000 | П.Уранбилэг 89086153 |
| 17 | Баянзүрх дүүрэг 6-р хороо, 13-р хороолол /13372/ Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж 65-р байрны зоорийн давхар 5 тоот тус бүр 12.5 м.кв талбайтай автозогсоол | 12,250,000 | Н.Цэрэнсодном 89086152 |
| 18 | Баянзүрх дүүрэг 6-р хороо, 13-р хороолол /13372/ Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж 65-р байрны зоорийн давхар 6 тоот тус бүр 12.5 м.кв талбайтай автозогсоол | 12,250,000 | Н.Цэрэнсодном 89086152 |
| 19 | Сүхбаатар дүүрэг 7-р хороо, 11-р хороолол 6-р байр 14 тоот 30 м.кв талбайтай 2 өрөө орон сууц | 87,500,000 | Б.Дэлгэрмөрөн 89086155 |
| 20 | Баянгол дүүрэг 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс Сонсголонгийн зам 22/01 тоот 756 м.кв талбайтай үйлчилгээний зориулалтай барилга, 306 м.кв талбайтай газрын хамт | 351,846,144 | Ш.Бямбадорж 89086180 |
| 21 | Чингэлтэй дүүрэг 3-р хороо, 2-р 40 мянгат 8-р байр 26 тоот 39.4 м.кв талбайтай 3 өрөө орон сууц | 84,394,800 | Ш.Бямбадорж 89086180 |
| ХОЁР. ХАШАА БАЙШИН, ГАЗАР | | | |
| 22 | Чингэлтэй дүүргийн 7-р хороо, Хувьсгалчдын гудамж 489а тоот хаягт байршилтай 41,5 м.кв талбайтай хувийн сууцны зориулалттай үл хөдлөх 293 м.кв гэр бүлийн хэрэгцээний зориулллатай газрын хамт | 13,674,150 | Б.Эрдэнболд 89086123 |
| 23 | Чингэлтэй дүүргийн 16-р хороо, Согоотын 31-р гудамж 395 тоот 120.55 м.кв талбайтай хувийн сууц гражийн хамт 688 м.кв талбайтай гэр бүлийн хэрэгцээний газрын хамт | 24,500,000 | Д.Отгончимэг 89086121 |
| 24 | Баянзүрх дүүрэг 28-р хороо, Хужирбулан 3-р хэсэг 40-р гудамж 1441 тоот 56 м.кв хувийн сууц 413 м.кв талбайтай газрын хамт | 18,615,475 | Г.Идэрчулуун 89086143 |
| 25 | Баянзүрх дүүрэг 11-р хороо, Усан сан 1а гудамж 15 тоот 700 м.кв талбайтай гэр бүлийн хэрэгцээний газар | 5,600,000 | В.Уранцэцэг 89086181 |
| 26 | Сонгинохайрхан дүүрэг 24-р хороо, Баруун салаа бумбатын амын 16 тоот 400 м.кв талбайтай зуслангийн газар | 10,500,000 | В.Уранцэцэг 89086181 |
| 27 | Сонгинохайрхан дүүрэг 32-р хороо Царцааны аж ахуйн замын урд байрлах 14155 м.кв талбайтай эзэмших эрхийг газар | 163,417,660 | П.Уранбилэг 89086153 |

## АЛБАДАН ДУУДЛАГА ХУДАЛДАА

Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанаас дараах үл хөдлөх эд хөрөнгө, орон сууц, барилга байгууламжийн 2 ДАХЬ албадан дуудлага худалдааг 2017 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 10 цагт албаны байранд зохион байгуулна. Оролцогчдыг 2017 оны 09 дүгээр сарын 27-ний өдрийн 14.00 - 17.00 цагийн хооронд Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны нэг цэгийн өрөөнд бүртгэнэ. Хугацаа хоцорсон хүсэлтийг хүлээн авах боломжгүйг анхаарна уу.

Бүртгүүлэхдээ дуудлага худалдааны дэнчингийн мөнгийг Улаанбаатар банкны 2617001560 тоот дансанд тушааж нэг хувийг авчирна уу. Хаяг: Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороо, Үндсэн хуулийн гудамж-3, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба

Цахим хаяг: http://www.nshga.cd.gov.mn, www.facebook.com/pages/Нийслэлийн-Шийдвэр-Гүйцэтгэх-Алба

| № | Үл хөдлөх эд хөрөнгийн хаяг байршил | Иргэний хуулийн 177 дугаар зүйлийн 177.4-д заасан санал болгох доод үнийг тохиролцсон болон үнэлгээчний тогтоосон зах зээлийн үнийн 50 хувь | Хариуцсан шийдвэр гүйцэтгэгч, утасны дугаар |
|---|---|---|---|
| НЭГ. ОРОН СУУЦ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖ | | | |
| 1 | Хан-Уул дүүргийн 11-р хороо Дүнжингарав гудамж 25 байр 1 тоот 240 м.кв талбайтай 2 өрөө амрагчийн сууцны зориулалттай 98 хувийн гүйцэтгэлтэй үл хөдлөх | 336,000,000 | Д.Долгорлхам 89086140 |
| 2 | Хан-Уул дүүрэг 11-р хороо, Ар Зайсан гудамж 101 байр 7 тоот 179,33 м.кв талбайтай 4 өрөө орон сууц | 269,000,000 | Д.Долгорлхам 89086140 |
| 3 | Баянгол дүүрэг 9-р хороо, 3-р хороолол /16093/ Хасбаатарын гудамжны 25-р байрны 38 тоот 44 м.кв талбайтай 2 өрөө орон сууц | 45,100,000 | А.Осорбурам 89086176 |
| 4 | Сонгинохайрхан дүүрэг 27-р хороо, 21-р хороолол ХД-ийн 46-р байр 23 тоот 53,7 м.кв талбайтай 2 өрөө орон сууц | 37,500,000 | А.Осорбурам 89086176 |
| 5 | Хан-Уул дүүргийн 13-р хороо Шувуун фабрик /17170/ Шувуун фабрикийн зам 45 тоот үйлдвэр агуулахын зориулалттай 864 м.кв талбайтай үл хөдлөх, Хан-Уул дүүргийн 13-р хороо Шувуун фабрик /17170/ Шувуун фабрикийн зам 45/1 тоот үйлдвэрийн зориулалттай 720 м.кв талбайтай үл хөдлөх 4181 м.кв газрын хамт | 1,195,000,000 | А.Солонго 89086188 |
| 6 | Баянгол дүүргийн 2-р хороо Энхтайваны өргөн чөлөө 55-р байр 35 тоот 51,5 м.кв талбайтай 2 өрөө орон сууц | 95,000,000 | А.Солонго 89086188 |
| 7 | Баянзүрх дүүрэг 7-р хороо 23 байр 31 тоот 27 м.кв талбайтай 2 өрөө орон сууц | 35,000,000 | Т.Ариунболор 89086187 |
| 8 | Чингэлтэй дүүрэг 4-р хороо Бага тойруу 41 байр 39 тоот 40 м.кв талбайтай 3 өрөө орон сууц | 50,743,400 | Б.Цэрэнчунт 89086124 |
| 9 | Баянгол дүүрэг 12-р хороо 6 бичил хороолол 13 байр 67 тоот 30 м.кв талбайтай 2 өрөө орон сууц | 55,000,000 | Б.Буянбадрах 89086144 |
| 10 | Сүхбаатар дүүрэг 18-р хороо Сэлхийн зусланд байрлах 1400 м.кв газар эзэмших эрхийн гэрчилгээтэй | 6,000,000 | Ж.Оюунжаргал 89086119 |
| 11 | Сүхбаатар дүүрэг 18-р хороо Сэлхийн зусланд байрлах 70 хувийн гүйцэтгэлтэй дутуу баригдсан 4 хувийн сууц | 9,800,000 | Ж.Оюунжаргал 89086119 |
| 12 | Сүхбаатар дүүрэг 18-р хороо Сэлхийн зусланд байрлах 80 хувийн гүйцэтгэлтэй дутуу баригдсан 1 хувийн сууц | 2,800,000 | Ж.Оюунжаргал 89086119 |
| 13 | Сүхбаатар дүүрэг 18-р хороо Сэлхийн зусланд байрлах дутуу баригдсан 7 ширхэг граш | 3,550,000 | Ж.Оюунжаргал 89086119 |
| 14 | Сүхбаатар дүүрэг 18-р хороо Сэлхийн зусланд байрлах 1 ширхэг под станц | 10,000,000 | Ж.Оюунжаргал 89086119 |
| 15 | Сүхбаатар дүүрэг 18-р хороо Сэлхийн зусланд байрлах 1 ширхэг 40 м гүний худаг | 2,600,000 | Ж.Оюунжаргал 89086119 |
| 16 | Баянзүрх дүүргийн 5-р хороо, Өлгий 11-р гудамж 155 тоот 566,6 м.кв талбайтай өмчлөх эрхтэй газар | 22,347,350 | Д.Мөнхбаяр 89086147 |
| 17 | Баянзүрх дүүргийн 1 дүгээр хороо, 12 дугаар хороолол, 25 дугаар байрны 01 тоот 29 м.кв талбайтай 2 өрөө орон сууц | 33.058.050 | Д.Мөнхбаяр 89086147 |
| 18 | Баянгол дүүргийн 8 дугаар хороо, 4 дүгээр хороолол, 16 дугаар байрны 40 тоот 40 м.кв талбайтай 3 өрөө орон сууц | 49.925.400 | Д.Мөнхбаяр 89086147 |
| 19 | Сүхбаатар дүүргийн 10 дугаар хороо, 26 дугаар байрны 29 тоот 47 м.кв талбайтай 3 өрөө орон сууц | 45.397.550 | Д.Мөнхбаяр 89086147 |
| 20 | Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо, Хонхор булгачин гудамжны 225 тоот 594 м.кв талбайтай үйлдвэрийн зориулалттай үл хөдлөх | 189.542.500 | Д.Мөнхбаяр 89086147 |
| 21 | Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо, Хонхор булгачин гудамжны 225 тоот 1400 м.кв талбайтай эзэмших эрхтэй газар | 4.962.500 | Д.Мөнхбаяр 89086147 |
| 22 | Баянгол дүүрэг 2-р хороо, 2-р хороолол Төмөр замын 26-р байр 32 тоот 54 м.кв талбайтай 3 өрөө орон сууц | 40,315,000 | В.Уранцэцэг 89086181 |
| 23 | Баянгол дүүрэг 6-р хороо, 10-р хороолол 83-р байр 20 тоот 44,95 м.кв талбайтай 2 өрөө орон сууц | 41,851,810 | В.Уранцэцэг 89086181 |
| 24 | Хан-уул дүүрэг 11-р хороо Стадион Оргил ХД-ийн 69-р байр 53 тоот 45,06 м.кв талбайтай 2 өрөө орон сууц | 32,500,000 | П.Уранбилэг 89086153 |
| ХОЁР. ХАШАА БАЙШИН, ГАЗАР | | | |
| 25 | Хан-Уул дүүргийн 13-р хороо 7-36а 11 тоот 700 м.кв эзэмших эрхтэй газар | 2,033,350 | Т.Адилбек 89086133 |
| 26 | Чингэлтэй дүүрэг 18-р хороо Яргайтын 42-р гудамж 703б тоот байрлах 72 м.кв хувийн сууц, 402 м.кв талбайтай газрын хамт | 9,188,401 | Н.Өнөржаргал 89086120 |
| 27 | Чингэлтэй дүүрэг 19-р хороо Доод салхит 5-р гудамж 95 тоот 212 м.кв тайлбайтай хувийн сууц, 700 м.кв газрын хамт | 35,000,000 | Б.Цэрэнчунт 89086124 |
| 28 | Сүхбаатар дүүрэг 19-р хороо, Санзайн 6-р хэсэг 662 тоот 96 м.кв талбайтай хувийн сууц, 700 м.кв талбайтай эзэмших эрхтэй газрын хамт | 21,035,000 | М.Хажидмаа 89086156 |

## ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ҮНЭ ХАЯЛЦУУЛАХ ДУУДЛАГА ХУДАЛДАА

Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанаас дараах хөдлөх хөрөнгийн үнэ хаялцуулах албадан дуудлага худалдааг 2017 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн 10 цагт албаны байранд зохион байгуулна. Оролцогчдыг 2017 оны 10 дугаар сарын 13-ний өдрийн 14.00 - 17.00 цагийн хооронд Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны нэг цэгийн өрөөнд бүртгэнэ. Хугацаа хоцорсон хүсэлтийг хүлээн авах боломжгүйг анхаарна уу.

Бүртгүүлэхдээ дуудлага худалдааны дэнчингийн мөнгийг Улаанбаатар банкны 2617001560 тоот дансанд тушааж нэг хувийг авчирна уу. Хаяг: Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороо, Үндсэн хуулийн гудамж-3, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба

Цахим хаяг: http://www.nshga.cd.gov.mn, www.facebook.com/pages/Нийслэлийн-Шийдвэр-Гүйцэтгэх-Алба

| № | Хөдлөх хөрөнгийн нэр | Үнэ хаялцуулах худалдан борлуулах үнэ | Тоо ширхэг | Хариуцсан шийдвэр гүйцэтгэгч, утасны дугаар | Эд хөрөнгө байгаа байршил |
|---|---|---|---|---|---|
| 1 | Лексус 570 маркын 2012 онд үйлдвэрлэгдсэн 2012 Монгол улсад орж ирсэн 2013 оны загварын хар өнгийн суудлын автомашин | 123,788,000 | 1 | А.Солонго 89086188 | НШГА автозогсоол |

## ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ҮНЭ ХАЯЛЦУУЛАХ ДУУДЛАГА ХУДАЛДАА

Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанаас дараах хөдлөх хөрөнгийн 2 дахь үнэ хаялцуулах албадан дуудлага худалдааг 2017 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн 10 цагт албаны байранд зохион байгуулна. Оролцогчдыг 2017 оны 10 дугаар сарын 13-ний өдрийн 14.00 - 17.00 цагийн хооронд Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны нэг цэгийн өрөөнд бүртгэнэ. Хугацаа хоцорсон хүсэлтийг хүлээн авах боломжгүйг анхаарна уу.

Бүртгүүлэхдээ дуудлага худалдааны дэнчингийн мөнгийг Улаанбаатар банкны 2617001560 тоот дансанд тушааж нэг хувийг авчирна уу. Хаяг: Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороо, Үндсэн хуулийн гудамж-3, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба

Цахим хаяг: http://www.nshga.cd.gov.mn, www.facebook.com/pages/Нийслэлийн-Шийдвэр-Гүйцэтгэх-Алба

| № | Хөдлөх хөрөнгийн нэр | Үнэ хаялцуулах худалдан борлуулах үнэ | Тоо ширхэг | Хариуцсан шийдвэр гүйцэтгэгч, утасны дугаар | Эд хөрөнгө байгаа байршил |
|---|---|---|---|---|---|
| 1 | Ниссан Тина маркын 2004 онд үйлдвэрлэгдсэн 2011.11.29-нд Монгол улсад орж ирсэн цагаан өнгийн суудлын автомашин | 4,410,000 | 1 | О.Цэрэннадмид 89086163 | НШГА автозогсоол |
| 2 | BMW маркын 2007 онд үйлдвэрлэгдсэн 2009.5.10-нд Монгол улсад орж ирсэн саарал өнгийн суудлын автомашин | 11,900,000 | 1 | О.Цэрэннадмид 89086163 | НШГА автозогсоол |

**НИЙСЛЭЛИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБА**

# ОНЦЛОХ ХУУДАС

Õýí íü õýí áý?

# ТҮГЭЭХИЙНХЭН



Ч.ЧУЛУУН

*"Хэн нь хэн бэ" булан Эрчим хүчний салбар дахь төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн дарга нараар үргэлжилж байгаа билээ. Энэ удаад орон нутагт үйл ажиллагаагаа явуулж буй Цахилгаан түгээх сүлжээ компаниудын гүйцэтгэх захирлуудыг онцолж байна.*

## Алдагдлыг ашиг руу шилжүүлсэн захирал

*/"Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ" ХК-ийн захирал /*

Энэ эрхмийг эрдэнэтчүүд андахгүй. Ялангуяа, уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийнхэн. Гуч шахам жил тогоонд нь буцалсан юм чинь арга ч үгүй биз. Засварчнаас ажил амьдралынхаа гарааг эхэлсэн Г.Баярцогт захирлын намтар бусдаас онцгойрох зүйлгүй энгийн. ОХУ-д дээд боловсрол эзэмшсэн. Инженер механикч мэргэжилтэй. Уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн харьяа Засвар механикийн заводод инженер, Зохион бүтээх хэлтэст инженер, ахлах инженер, "Эрдэнэт" концерний харьяа "Бүтээл" улсын үйлдвэрийн газрын дарга, "Эрдэнэт" үйлдвэрийн Худалдан авах цехийн дарга, "Бүтээл" ХХК-ийн ерөнхий захирлаар тус тус ажиллаж байгаад 2016 оноос "Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ" ХК-ийн гүйцэтгэх захирлаар томилогдсон гээд л хэдхэн өгүүлбэрт багтах жишээтэй. Гэхдээ тэр хашиж байсан албан тушаалууд дээрээ дандаа өсч дэвшиж ирснийг энд онцлох ёстой болов уу. Ийн хэлэхийн учир Г.Баярцогтыг эрчим хүчнийхэн "манай салбарын хүн биш" хэмээн гоочилж мэдэх ч "Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит компаний гүйцэтгэх захирлаар ажилласан жил гаруйн хугацаанд багагүй зүйлийг хийж гүйцэтгэсэн нь зарим талаар хамт олондоо цаашлаад салбартаа хэн болох эхлэлээ амжилттай тавьсан гэж дүгнэж болохоор. Тухайлбал, түүнийг ажил хүлээж авахад тус хувьцаат компани 1.9 тэрбумын алдагдалтай ажиллаж байсан бол жилийн эцэст өөрөөр хэлбэл, 2016 оны дөрөвдүгээр улиралд тодорхой зардлуудыг бууруулан ажилласнаар 2016 оны эцсийн санхүүгийн тайлангаар 69,6 сая төгрөгийн, 2017 оны эхний хагас жилд 1.146,5 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байх юм. Мөн 2017 оны эхний найман сарын байдлаар ажиллагсдын нийгмийн дэмжлэгийн зардалд 818.4 сая төгрөг зарцуулсан нь өмнөх оны мөн үеэс 30 гаруй хувиар өсчээ. Түүнчлэн ажилтан, албан хаагчдынхаа нийгмийн асуудалд онцгой анхаарал хандуулж, орон сууцжуулах, залуу гэр бүлийг дэмжих зорилгоор 30 айлын орон сууцны төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлсэн нь ирэх улиралд ашиглалтад хүлээлгэн өгөх гэж байна. Үүгээр ч зогсохгүй орон сууцанд хамрагдах 0 ажилтныг сонгон шалгаруулж, урьдчилгаа төлбөрийн хөнгөлөлтөд 240.0 сая төгрөг олгосон нь ажилтнуудад бодит дэмжлэг болж чадсан төдийгүй компанийн түүхэнд анхдагч болж үлдэхүйц үйл явдал болох нь дамжиггүй. Мөн өнгөрсөн хугацаанд компанийнхаа авто паркийг бүрэн шинэчилжээ. Ийм нэг эрхэм Монгол Улсын нэрийн хуудас болсон "Эрдэнэт "үйлдвэр хийгээд Орхон, Булган аймгийн хэрэглэгчдийг цахилгааны найдвартай эх үүсвэрээр хангах үүрэг бүхий хамт олныг удирдан ажиллаж байна.

## Хэрэглэгчдэд нүүртэй С.Нэргүй

*/Дархан-Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК-ийн захирал/*

Тус хувьцаат компаний Олон нийттэй харилцах албаны ажилтан бүсгүй "Манай дарга өөрийнхөө тухай, тэр дундаа "би" ингэж ажилласан гээд ярих нь юу л бол" хэмээсэн нь С.Нэргүй захирлыг ам чангатай хүн болохыг тойруу утгаар хэлж өгсөн гэлтэй. Нөгөөтэйгүүр, улс төр байнга бужигнах болсон энэ цаг үед түүн шиг нэг байгууллагыг найман жил удирдсан захирал эрчим хүчний салбарт ховор биз ээ, шулуухан хэлэхэд. Нөгөөтэйгүүр, тэрбээр Дархан-Сэлэнгэ гэх том бүсийг эрчим хүчний найдвартай ажиллагаагаар хангахын төлөө найман жил хамт олноо удирдан зүтгэхдээ нэг ч удаа хэвлэл мэдээллийн байгууллагад ярилцлага өгөөгүй байх юм. Магадгүй энэ нь түүний сул тал байхыг үгүйсгэхгүй. С.Нэргүй гэж хэн бэ гэх хувь хүнийх нь тухайд хэлээд өгөх хүн тэр бүр тааралдаагүй ч юу хийж, юу бүтээж яваа талаар нь өгүүлэх мэргэжилтэн олон байв. Тиймээс энэ хүний тухай "Хэрэглэгчдэд нүүртэй л хүн юм байна" гэх бодол юун түрүүнд төрсөн. Тус сүлжээ компани нь Сэлэнгэ аймгийн Баруунбүрэнгээс бусад сумд, Дархан-Уул аймгийг тэр чигээр нь цахилгаан эрчим хүчээр хангах үүрэг хүлээхээс гадна Төв аймгийн хойд хэсгийн зургаан сумыг хамарсан үйлчилгээ үзүүлдэг гэхээр ямар өндөр ачаалал үүрдэг болох нь хэн хүнээр хэлүүлэлтгүй харагдаж буй биз ээ. Тооны хэлээр өгүүлэхэд эднийх 47 мянган хэрэглэгчтэй. Нөгөөтэйгүүр, салбарынх нь яам тус байгууллагыг хөрөнгө оруулалт дээр бусдыг хошуучилж ажилласан хэмээн онцолсон явдал. Тодруулбал, 2015 онд зургаан тэрбум, 2016 онд 7.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг амжилттай гүйцэтгэж чадсан төдийгүй 2017 онд 9.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ард гарахаар зүтгэж байгаа аж. Хамгийн гол нь тэд бүхнийг улсын төсвийн хөрөнгөөр шийднэ гээд гараа хумхиж суулгүйгээр дотоод нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглаж чаддаг нь тэр хэрээр амжилт дагуулдаг буй за. Тухайлбал, өндөр өртөг шаарддаг бетонт тулгуурыг өөрсдөө үйлдвэрлэж эхэлснийг дурьдах байна. Мөн бүсийн хэмжээнд ухаалаг тоолуурын системийг амжилттай нэвтрүүлсэн нь үр дүнгээ өгсөн ажил болжээ. Эцэст нь тэмдэглэхэд, Дархан-Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК 2015 оноос алдагдалгүй ашигтай ажиллаж байгаа нь компани санхүү эдийн засгийн хувьд хөл дээрээ баттай зогсохын суурь тавигдсан гэж дүгнэж болох аж.

## "Эрсдэл заримдаа амжилт дагуулах нь бий"

*/"Багануур Зүүн Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ХК-ийн захирал/*

Энэ бол "Багануур Зүүн Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит ХК-ий гүйцэтгэх захирал Н.Тавинбэхийн яриан дундуураа онцолсон үг. Гэхдээ мань хүн эл үгийг олон утгатайгаар хэлсэн гэдгийг ярианых нь төгсгөлд олж мэдсэн хэрэг. Тэрбээр эрчим хүчний салбарт бүхий л насаараа эрдэм боловсрол, сэтгэл оюунаа зориулсан хоёр буурлын том хүү нь юм билээ. Дүү нь цаг бусаар хорвоог орхиогүйсэн бол эдүгээ ахтай-гаа мөр зэрэгцэн ажиллаж байх байлаа. Тэр бас эрчим хүчний хүн байж. Энэ бүхнийг сонсч суухад Н.Тавинбэх захирал "Эцэг, эхийнхээ гаргасан зам мөрийг өөрийнхөөрөө улам тодруулахаас гадна дүүгийнхээ хийж амжилгүй дутуу орхисныг нь гүйцээх үүргийг өөртөө хүлээсэн нэгэн юм даа эдүгээ гэх бодол төрж суусныг нуух юун. Насны хувьд харьцангүй залуу харагддаг ч мөр зэрэгцэн ажиллах хамт олон, салбарынхан нь түүнийг санаж сэдэж, түүнийгээ гүйцэлдүүлэхийн төлөө хичээл зүтгэл гаргаж байгаа байдал нь газрын даргын энтэй инженер хэмээн дүгнэх юм билээ. Н.Тавинбэх ШУТИС–ийг 1995 онд цахилгааны инженер мэргэжлээр төгссөн. Түүний намтар бусдаас арай өөр. "Багануур Зүүн–Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-д гүйцэтгэх захирал, "Багануур энерги" ХХК-ийн захирал, Багануур дүүргийн Засаг дарга гээд л. Дунд нь улс төрийн албан тушаал ороод ирж байгаа биз. Тэрбээр хоёр жилийн өмнө 6000 гаруй хүн амтай дүүрэг удирдаж явсан бол эдүгээ зүүн өмнөд бүсийг цахилгаан эрчим хүчээр хангах үүрэг хүлээн ажиллаж буй. Түүнд аль алинд нь ажиллах ажлын туршлага хийгээд эрдэм боловсрол, хичээл зүтгэл бий. Хамт олон ч нь зүүн өмнөд бүсийг эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангах үүргээсээ нэг ч алхам ухраагүй.

# ЧУХАЛ СЭДЭВ

## БАГШИЙН ЦАЛИН ХӨЛСНИЙ ШИНЭ ТОГТОЛЦООГ НЭВТРҮҮЛНЭ

НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН
ГАЗАР, АЙМГИЙН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН
ДАРГА НАРТ

Багшийн цалин хөлсний шинэчлэлийн тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.11 дэх зорилт, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 14.13 дахь зорилт, арга хэмжээнд "багш, эмч, эмнэлгийн ажилтнуудын ажлын ачаалал, ур чадвар, мэргэшил, ажлын үр дүн, ажилласан жил зэргээс хамаарсан цалин хөлс, урамшууллын тогтолцоог бий болгоно" гэж заасан. Мөн Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбоо, "Багшийн цалинг нэмүүлэх түр хороо"-оос багшийн цалинг нэмэгдүүлэх шаардлагыг Монгол Улсын Засгийн газарт хоёр дахь удаагаа хүргүүлээд байгаа билээ.

Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэх, багш ажилтны цалин хөлсийг боловсронгуй болгох талаар санал боловсруулах үүрэг бүхий гурван яамны төлөөллөөс бүрдсэн ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын хамтарсан тушаалаар байгуулаад байна.

Тус яамнаас багшийн цалин, хөлсний шинэ бодлогыг боловсруулж байгаатай холбогдуулан багшийн цалин хөлс, урамшууллын эрх зүйн зохицуулалтыг хянах, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын нийт багш, боловсролын хамт олныг хамарсан нээлттэй хэлэлцүүлгийг улс орон даяар зохион байгуулах ажлыг эхлүүлж байна.

Иймд Та бүхэнд дараах арга хэмжээг зохион байгуулахыг үүрэг болгож байна. Үүнд:

1. Энэхүү албан захидлаар хавсарган хүргүүлж буй "Багшийн цалин хөлсний шинэчлэлийн бодлогын үзэл баримтлал"-ын төслийг цэцэрлэг, сургууль бүрт хүргэх;

2. Цалин хөлсний шинэчлэлийн нээлттэй хэлэлцүүлгийг цэцэрлэг, сургууль тус бүр дээр зохион байгуулах;

3. Нээлттэй хэлэлцүүлгийн санал, дүгнэлтийг нэгтгэн 2017 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн дотор тус яаманд цахим хэлбэрээр болон бичгээр ирүүлэх.

Энэхүү захидлаар хүргүүлж буй үүргийн хэрэгжилтийн эхний тайланг 2017 оны 9 дүгээр сарын 20-ны дотор тус яаманд цахим хэлбэрээр ирүүлнэ үү.

Хавсралт: "Багшийн цалин хөлсний шинэчлэлийн бодлогын үзэл баримтлал"-төсөл /2 хуудас/

Хүндэтгэсэн,

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ Г.ЛУУНБААТАР

## БАГШИЙН ЦАЛИН ХӨЛСНИЙ ШИНЭЧЛЭЛИЙН БОДЛОГЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

**Нэг. Баримтлах зарчим**

Багшийн цалин, хөлсний шинэчлэл нь дараах зарчимд тулгуурлана. Үүнд:

- Багш хөдөлмөрийн үнэлэмж, үнэ цэнийг бодитой өргөх;
- Багшийн цалин хөлс нь амьдрал, ахуйн зайлшгүй хэрэгцээг хангадаг байх;
- Багшийн үндсэн цалин нь хөдөлмөрийн онцлог, нөхцөл, ачаалалтай уялдсан, ялгаатай байх;
- Багшийн цалин хөлс нь ажлын үр дүнтэй шууд хамааралтай байх;
- Багшийн ажлын чиг үүрэг, үнэлгээ нь тодорхой байх;
- Багшийн ажлын үнэлгээний зорилго, үнэлэх шалгуур, үзүүлэлт нь хөдөлмөрийн чиг үүрэгт нь нийцтэй байх;
- Багшийн ажлын үнэлгээ нь үнэн, шударга, ил тод, нээлттэй байх.

**Хоёр. Шийдэх асуудал**

Багшийн цалин хөлсний шинэчлэл нь дараах асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдэнэ. Үүнд :

- Багшийн хөдөлмөрийн үнэлэмж, ачааллыг хянан судалж, багшийн ажлын чиг үүргийг шинжлэх ухааны үндэстэй тогтоож, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэх;
- Багшийн ажлын байрны үнэлгээг хийж, үндсэн цалинг нэмэгдүүлэх, албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэх асуудлыг шийдвэрлүүлэх;
- Багшийн ажлын норм, нормативуудыг хянаж, шинэчлэх;
- Цэцэрлэгийн багш, бага ангийн багшийн үндсэн цалинг хөдөлмөрийн онцлог, нөхцөл, ачаалалтай нь уялдуулж ялгаатай тогтоож, үндсэн цалинг нэмэгдүүлэх;
- Нормативаас хэтэрсэн бүлэг дүүргэлтийг ажлын нэмэлт ачаалалд тооцож, үнэлгээтэй болгох;
- Хүүхдийн хөгжлийн ахиц өөрчлөлт, сургалтын үр дүнд суурилсан багшийн ажлын үнэлгээний тогтолцоог бий болгох;
- Багшийн мэргэжлийн зэрэгт тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг багшлах үйл ажиллагаа, сургалтын чанар, үр дүнтэй шууд хамааралтай болгон шинэчлэх;
- Мэргэжлийн зэрэгт тавигдах шаардлагыг ажилласан жилийн хугацаанаас илүүтэй ажлын үр дүн, чанараас шууд хамааралтай болгох /багш үр дүнтэй, амжилттай ажиллаж байгаа тохиолдолд цалингийн 10 хувийн нэмэгдэлтэй арга зүйч мэргэжлийн зэргийг авах гэж 5 жил, 15 хувийн нэмэгдэлтэй тэргүүлэх мэргэжлийн зэргийг авах гэж 10 жил, 20 хувийн нэмэгдэлтэй зөвлөх мэргэжлийн зэргийг авах гэж 15 жил хүлээх шаардлагагүй болно/;
- Мэргэжлийн зөвлөх, тэргүүлэх зэрэг олгох, цуцлах эрхийг сургууль, хамт олны мэдэлд шилжүүлэх;
- Кабинет, лаборатори нээн ажиллуулах эрхийг сургуульд шилжүүлэх;
- Багшид сар бүр үр дүнгийн урамшууллын 10 хувийн нэмэгдлийг тогтмол олгож, ажлын гүйцэтгэл, үр дүнгээс хамаарч 5 хувиар нэмэгдүүлэн авах боломжийг бий болгох;
- Багшийн цалин хөлсийг мэргэжлийн ур чадвартай нь уялдуулан ялгаатай тогтоох, багшийг мэргэжлээ тасралтгүй дээшлүүлэх нөхцөлийг хангасан мэргэжил дээшлүүлэх үндэсний тогтолцоог бий болгох;
- Бага ангийн багшийн дэвтэр засах ажлыг үнэлэмжтэй болгох;
- Хүүхдийн хөгжил, төлөвшлийг дэмжихэд чиглэгдсэн секц, дугуйлан хичээллүүлэх ажлыг санхүүжилттэй болгох;
- Хичээлийн жилийн улирлын амралт болон бусад давагдашгүй хүчин зүйлээр сургууль хичээллээгүй боловч багш нар үндсэн ажлаа гүйцэтгэж байгаа тохиолдолд үндсэн цалингаас тооцон олгогддог зарим нэмэгдэл, нэмэгдэл хөлсийг олгодог болгох;
- Сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч, сургалтын менежер, цэцэрлэгийн арга зүйчийн цалин хөлсийг ажлын чиг үүрэг, ачаалалтай нь уялдуулан шинэчлэх;
- Нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын норматив, хичээл практикийн зардлыг хянаж, сургалтын хэвийн үйл ажиллагаа явуулах санхүүгийн нөхцөлийг бүрдүүлэх;
- Сурагчийг үнэлэх үнэлгээний зорилт, шалгуур, үзүүлэлтийг шинэчлэх;
- Багшийн дүн, шалгалтын дүн үнэн, бодитой байдаг өөрийн үнэлгээний тогтолцоог бий болгох;
- Багш, сургуулийн сургалтын чанар, үр дүнг хөндлөнгөөс бодитойгоор хянадаг үнэлгээний тогтолцоо, шалгалтын системийг бий болгох;
- Багш, сургуулийн сургалтын чанар, үр дүнг ил тод, нээлттэй болгох;
- Боловсролын байгууллага хуулиар хориглогоогүй үйл ажиллагаа явуулж орлого олох, зарцуулах санхүүгийн нээлттэй нөхцөл бололцоог бүрдүүлж, байгууллагын түвшинд багш, ажилтны цалин орлого нэмэгдүүлэх боломжийг өргөжүүлэх;
- Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн цалингийн сан бүрдүүлэлт, хуваарилалтын санхүүгийн механизмыг хянаж, багшийн цалингийн санг нэмэгдүүлэх бололцоог бий болгох;
- Боловсролын төсвийн бүтэц, хуваарилалтыг хянаж, цалингийн санг нэмэгдүүлэх бололцоог судалж, шийдвэрлэх;
- Бусад...

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ**



Э.ТУУЛ

*Орхон аймгийн Жаргалант сумын Айрагийн гозгор гэх газраас олдсон Хүннүгийн хожуу үе Сяньбигийн эхэн үед хамаарах бүлэг дурсгалд малтлага хийх ажил дөрөв дэх жилдээ үргэлжилж байгаа билээ. Малтлага, судалгааны ажлыг Монголын Үндэсний музей, Орхон аймгийн музейн мэргэжилтнүүд хийсэн юм. Энэ талаар Малтлага, судалгааны ажилд гар бие оролцож буй Орхон аймгийн музейн Эрдэм шинжилгээний ажилтан М.Ганцэцэгтэй ярилцлаа.*

**-Орхон аймгийн Жаргалант сумын Айргийн гозгор гэх газраас их ховор олдворууд олдсон талаархи мэдээлэл хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдсан. Хэчнээн булш, бунхан тэнд байна. Яг ямар олдворууд олдсон талаар ярилцлагаа эхлэх үү?**

-Манай аймгийн Жаргалант сумын нутаг Айрагийн гозгор гэх газраас Хүннүгийн хожуу үе, Сяньбигийн эхэн үед хамаарах бүлэг булш оршуулганд малтлага судалгаа хийх ажил 2014 онд эхэлж, өнөөдрийг хүртэл үргэлжилж байна. Эхэндээ археологичид тэнд 92 булш байна гэж тогтоосон байдаг боловч хамгийн сүүлийн үеийн судалгаагаар 102 булш болж нэмэгдсэн. Үүнээс дөрвөн жилийн хугацаанд 13 булшийг малтсан. Гэхдээ тэдгээр булшнуудын ихэнх нь тоногдсон байсныг эрдэмтэд хэлж байна билээ. Өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд нийт 13 булш малтсаны хамгийн сүүлийнх нь тоногдоогүй байсан. Энэ булш Хүннүгийн сүүл үе, Сяньбигийн эхэн үед холбогдоно гэж судлаачид ярьж байгаа. Гэхдээ энэ мэдээлэл бүрэн батлагдаагүй. Иймээс бид энэхүү газар судалгаа явуулж, уг дурсгалтай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг олж, тэдгээрийг хэн, хэзээ үйлдсэн, ямар аж ахуй, соёлтой ард түмэн байсныг тодруулах зайлшгүй шаардлага урган гарч байна.

**-Айргийн гозгорын олдвор дээр нэлээд олон хүний бүрэлдэхүүнтэй баг ажилласан гэж сонссон юм байна?**

-Үндэсний түүхийн музейгээс хэрэгжүүлж буй хээрийн малтлага судалгаанаас илэрч буй олдвор дээр хээрийн нөхцөлд стандарт сав баглаа боодолд боож, олдворыг гадны нөлөөнөөс хамгаалж, хадгалалт хамгаалалтын арга зүй авах талын сургалтын ажилд Монголын талаас Соёлын өвийн төв, Хархорум музей, Дүрслэх урлагийн музей, Орхон аймгийн музей, Улаанбаатар Их Сургууль, Японы талаас Нара Их сургууль Оосакагийн соёлын өвийн хадгалалт хамгаалалтын хүрээлэн, Кьюшю орон нутгийн музейн мэргэжилтнүүд оролцож, харилцан туршлага солилцож хээрийн дадлага ажил хийсэн. Энэхүү малтлагын ажилд гадаадын маш олон байгууллагууд хамтран ажиллаж байгаа. Мөн АНУ-ын Калифорни мужийн их сургуулийн багш, доктор Кристине Лее сүүлийн дөрвөн жилийн турш ажиллаж байна. Мөн малтлагаар гаргаж ирсэн олдворыг хадгалах, хамгаалах тал дээр Японы Нарагийн их сургуулийн хадгалалт, хамгаалалтын хүрээлэнд докторын зэрэг хамгаалсан М.Оюунтулга ажиллаж байна. Газрын гүнд 90 хэмийн чийгшилтэй газарт байсан олдвор газрын хөрсөн дээр буюу 20 хэмийн чийгшилд гараад ирэхээр устаж үгүй болох аюултай. Тиймээс газрын гүн дэх тэр чийгшлийг хэрхэн хадгалах, яг тийм орчныг хэрхэн бий болгохыг М.Оюунтулга доктор, 2017 оны олдвор дээр туршиж үзсэн. Ер нь манайд олдворыг хадгалах, хамгаалах тал дээр нэлээд асуудалтай. Малтаад л байдаг, малтаад л байдаг. Гараад ирсэн зүйлийг нь яаж хадгалах, хэрхэн сэргээн засварлах вэ гэдэг нь асуудал болж байгаа юм. Харин энэ жилээс Япон улстай хамтраад, газар дээр нь хээрийн нөхцөлд хадгалж хамгаалах, сэргээн засах, гаргаад ирсэн олдворыг яг тэр хэвээр нь Соёлын өвийн төвд аваачиж, сэргээн засварлаад музейд тавьж, ард түмний хүртээл болгох ажлыг хэрэгжүүлж эхлээд байна.

**-Одоогийн байдлаар хэчнээн булш бунхнаас ямар олдворууд илрээд байгаа вэ?**

-Монголд Хүннүгийн үеийн булш маш олон бий. Харин Сяньбигийн үед холбогдох булш байхгүй. Хэрэв Айргийн гозгорын 102 булш Сяньбигийн үед холбогдвол Монголын нутаг дэвсгэрээс олдсон анхны булш болно. БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах оронд Сяньбигийн үеийн булш маш их байдаг юм байна. Тэнд магистрын зэрэг хамгаалсан монгол залуу Айргийн гозгорын олдвор дээр ажиллаж байгаа. Айргийн гозгорын том булш маань олон улсын хараанд нэгэнт өртчихсөн. Олон улсын хамтын ажиллагаагаар цаашид үргэлжлэх бүрэн боломжтой. Энэ онд Айргийн гозгорын 7, 53, 89 гэсэн гурван булшийг малтсан. Эхний 53 дахь булш хүүхдийн булш байсан. Тонуулчид тоночихсон байсан учраас юу ч илрээгүй. Долдугаар булш маш том бөгөөд хос булш байсан. Мөн л тонуулчид аль хэдийнэ тоночихсон байсан. Гэхдээ нэг булшнаас нь гурван ваар, нэг пийшин, бас түүн дээр тавьсан хоёр таваг шиг зүйл олдсон. 89 дүгээр булш бол огт тоногдоогүй байсан. Тоногдоогүй булшнаас одоогийн байдлаар модон морь, модон үхэр, модон аяга, ширээ гэх мэт зүйлүүд гарсан. Гэхдээ судлаачид судалж байгаа. Сэргээн засах үйл явцыг нь Монголд анх удаа Японоос авчирсан сахарын уусмалаар хийж байна. Энэ ажилд Соёлын өвийн мэргэжилтэн, Орхон аймгийн музейгээс миний бие, М.Оюунтулга бид гурав ажиллаж байна. Олны хүртээл болоход цаг хугацаа их шаардагдана.

**-Судалгаа шинжилгээ болон малтлагын ажил цаашид үргэлжлэх нь. Хэдэн он хүртэл үргэлжилнэ гэж тооцсон бэ. Энэ ажилд орон нутгаас санхүүжилт өгч байгаа юу?**

-Хэдий хэр хугацаанд үргэлжлэхийг нь нарийн хэлж мэдэхгүй байна. Монгол Улсын хэмжээнд малтлагын үйл явцад монголчууд өөрсдөө үндэсний экспедиц гаргаад, орон нутаг нь санхүүжүүлээд явж байгаа тохиолдол манайхаас өөр байхгүй. Бусад газрууд АНУ, Казахстаны хөрөнгө оруулалтаар маш олон малтлагыг хийж байгаа. Харин Айргийн гозгорын олдворыг орон нутгаас хоёр жилийн хугацаанд санхүүжүүлэн, дэмжиж ажиллаж байгаа.

**-Та модон эдлэл гарч ирсэн гэж хэлсэн шүү дээ. Тэр эдлэл хүүхдийнх, эсвэл насанд хүрсэн хүний эдлэж хэрэглэж байсан зүйл ч гэх юм уу. Урьдчилсан байдлаар тогтоосон зүйл байгаа болов**

# М.ГАНЦЭЦЭГ: АЙРАГИЙН ГОЗГОРЫН ОЛДВОРЫГ ОРОН НУТГААС САНХҮҮЖҮҮЛСЭН, ЭНЭ БОЛ МОНГОЛДОО АНХНЫ ТОХИОЛДОЛ

**уу?**

-Байлгүй яах вэ. Судалгааны ажил гэдэг өөрөө маш нягт нямбай ажиллагааг шаарддаг. Эхний ээлжинд рентген зургийг нь авна. 89 дүгээр булш огт тоногдоогүй байсан тухай дээр дурьдсан. Хүнээ ороогоод тухайн үед эдлэж хэрэглэж байсан маш олон зүйлийг булшинд нь хийсэн байсан. Хамгийн гол нь тэдгээр эдлэл муудчихсан байх жишээтэй. Тиймээс эхний ээлжинд рентген зураг аваад дотор нь юу юу байгааг хардаг. Монгол Улс өөрөө тэдгээр олдворын он цагийг хэдий үеийнх болохыг нь тогтоох боломжгүй. АНУ ч юм уу, гадаадын улс орон руу дээж явуулж аль үед хамаарагдахыг нь судлуулдаг. Мод, металлын дээжээс М.Оюунтулга Япон руу авч явж, судалж, тогтооно. Ямар мод вэ, юунд зориулагдсан эдлэл вэ гэдгийг тэнд тогтоох юм. Хүмүүсийн дунд нэг буруу ойлголт байдаг юм. Олоод малтаад, гаргаж ирээд шууд музейд тавьчих юм шиг ойлголттой байгаад байдаг. Монгол Улсын хувьд олдвор, булшийг малтах үндэсний экспедиц нь байна. Хамгийн гол нь гаргаад ирсэн зүйлийг яаж анхны байдлыг нь эвдэхгүйгээр сэргээн засварлаж, хадгалж хамгаалах вэ гэдэг дээр дутмаг, хэцүү төвшинд байгааг би саяхнаас л мэдэж байна. Би Айрагийн гозгорын олдвор дээр долдугаар сарын 23-наас хойш л ажиллаж байна. Тэнд 20 хоног малтлага дээр байсан. Сүүлийн 20 гаруй хоног сэргээн засварлалт дээр ажиллаж байна. Монголын соёлын өвийг сэргээн засварладаг СӨТ дээр манай олдворууд сэргээн засварлагдаж байна. Тэнд ганцхан манай Айрагийн гозгор биш, Монгол Улсын хэмжээнд олдож байгаа бүх олдворуудыг сэргээн засварлах ажил хийгддэг. Харамсалтай нь, 2017 оных нь төсөвт манай Айрагийн гозгорын олдворыг сэргээн засварлахажилтөсөвлөгдөөгүй. Тэгээд санхүүжилт хайгаад орон нутгийнхаа удирдлагууд, Монголын Үндэсний музейгээс дэмжлэг хүсээд, Японд төсөл бичээд шинээр гаргаж байгаа сахарын уусмал гэдэг бодисыг оруулж ирэх талаар ярьж байна. Энэ бодис нь Японд 20 жил туршигдаж байгаа. Тэрийг судалж, олдворыг бэхжүүлэх ажлыг хийдэг Японы топ таван эрдэмтэн байдгийн гурав нь Айргийн гозгор дээр ирж ажилласан. Үүгээрээ давуу талтай. Японд олдсон олдворууд нэг төрлийн л мод байдаг юм байна. Гэтэл Монголд маш олон төрлийн мод байдаг. Тэр асуудлыг газар дээр нь ирж хараад явсан хүний хувьд очоод томоохон төсөл бичээд хөрөнгө оруулалт сэргээн засах ажилд туслалцаа үзүүлэх бүрэн боломжтой гээд Монголоос манай музей, Хархорингийн музей, Дүрслэх урлагийн музей, Богд хааны музей, Соёлын өвийн төв гээд одоогийн байдлаар зургаан газраас хүмүүс явж сургалтад нь хамрагдаад Айрагийн гозгорын 2017 оны олдвор дээр ирэх оны наймдугаар сар хүртэл ажиллана гэсэн төлөвлөгөө гаргасан. Ингэж ажиллахдаа тэдгээр ажилтнууд хуваагдаж ажиллана. Орон нутгаас Улаанбаатар руу явж ажиллаж байгаа шүү дээ. Би ганцаараа орон нутгаас явья гэхээр ар гэр, амьдралтай хүн учраас асуудал мундахгүй. Үүнийг аль аль талдаа шийдэхээр тохироод ажил маань эхлээд явж байгаа. Одоогийн байдлаар эхний дөрөв, таван олдвороо сахарын уусмалдаа хийгээд хатаагч бодисноосоо гаргаад биежүүлэх ажил явагдаж байна. М.Оюунтулгыг байх хугацаанд арга зүйгээ сайн заалгаад үлдвэл бид хийж чадна гэж бодож байгаа.

> ...Айргийн гозгорын том булш маань олон улсын хараанд нэгэнт өртчихсөн. Олон улсын хамтын ажиллагаагаар цаашид үргэлжлэх бүрэн боломжтой. Энэ онд Айргийн гозгорын 7, 53, 89 гэсэн гурван булшийг малтсан. Эхний 53 дахь булш хүүхдийн булш байсан. Тонуулчид тоночихсон байсан учраас юу ч илрээгүй. Долдугаар булш маш том бөгөөд хос булш байсан. Мөн л тонуулчид аль хэдийнэ тоночихсон байсан...

**-Ерөнхийдөө модон эдлэлүүд их мууддаг юм байна. Төмөр эдлэлүүд гайгүй байдаг байх нь ээ?**

-Таван ваар бүтнээрээ олдсон. Сэргээн засварлах ямар ч шаардлагагүй эдлэлүүд олдож байгаа байхгүй юу. Модон эдлэл их хэцүү юм билээ. Модон эдлэлийг яаж сэргээн засварлаж, хадгалж хамгаалах вэ гэдэг асуудлыг Японд 11 жил сурсан М.Оюунтулга шийдсэн. Тэр хувиасаа мөнгө гаргаад Японы хэд хэдэн эрдэмтэн мэргэжилтнүүдийг удаа дараа авчираад, олдворуудыг боох сав баглаа боодлыг нь хүртэл авчирч байгаа юм. Энэ залууг монголчууд үнэлэх ёстой. Судалгаа шинжилгээний ажилд хувиасаа хөрөнгө зарцуулж байна шүү дээ.

**-Ер нь манайд түүхэн дурсгалт олдворууд маш их байгаа юм байна. Харин сэргээн засварлах ажил дутмаг байгаа юм байна. Үүнээс гадна Айрагийн гозгороос олдсон олдворууд хэзээ музейд ирэх вэ?**

-Тийм ээ. Соёлын өвийн төв маань одоо ямар байранд байгаа билээ. Төвийн байр нь баригдсан ч төр, засгаас санхүүжилтийг нь шийдвэрлэж өгч чадахгүй байгаа гэсэн. Монголын археологичид нэгдүгээр сард эрдэм шинжилгээний хурлаа хийдэг. Бүтэн жилийнхээ ажлыг дүгнэдэг гэсэн үг шүү дээ. Тэр хүртэл ажиллана. Наймдугаар сарын 07-ноос эхлээд олдвороо аваад Соёлын өвийн төв дээр аваачсан. Шинэ туршилт явагдаж байгаа учраас цаг хугацаа их шаардагдана. Ер нь багадаа жилийн хугацаа шаардлагатай. Бүгдийг нь сэргээн засварлаад аймгийн музейд авчирахад шүү дээ. Үүнд маш олон асуудал тулгарна. Тэр бүрийг бид амжилттай даван туулснаар аймгийн музейдээ авчираад 2014-2017 оны хооронд малтсан олдворуудаараа томоохон хэмжээний үзэсгэлэнг гаргаснаар хүмүүс ойлгох байх.

**-Ерөнхийдөө орон нутгаас олдсон үзмэрүүдийг хотын музей авчихдаг уу, эсвэл танай аймгийн нутаг дэвсгэрээс олдсон болохоор танай өмч байх учиртай юу?**

-Малтлага хийх эрхийг нь өгдөг газар бол БСШУСЯ. Хаанаас санхүүжилт гарах вэ гэдгийг бас шийдвэрлэнэ. Ерөнхийдөө манай Орхон аймгийн хувьд музейд үзмэр авах ямар ч төсөв байхгүй. Гэтэл орон нутаг 2015 онд 30 сая, 2017 онд 38 сая төгрөгийн төсвийг Айргийн гозгорын малтлагад гаргаад, олдсон олдворуудыг нь музейдаа авчирч байгаа энэ үйл явц бол музейнхээ үзвэр, сан хөмрөгийг баяжуулж байна гэсэн үг. Тэгэхээр манай аймаг томоохон зүйлийг хийгээд, хэрэгжүүлээд эхэлчихсэн. 2014, 2016 онд Монголын Үндэсний музей санхүүжилтээ олоод, олдсонолдвороо аваадявчихсан. Санхүү төсвөө гаргасан тал нь давуу эрхтэй. Тэгэхээр аймаг маань буруу зүйлд мөнгөө зарцуулахгүй байгаагийн илрэл энэ гэж хэлэх байна. Эдгээр олдворууд 2000 жилийн өмнөх үед хамаарч байгаа шүү дээ. 2000 жилийн өмнөх газрын хөрсөнд байгаа олдворуудыг аймаг санхүүжүүлээд, газрын гүнээс гаргаж ирээд, сэргээн засварлуулаад, тодорхой цаг хугацааны дараа музейд ирээд бусдын хүртээл болж байгаа нь л хамгийн чухал. Дахиад хэдэн жил хадгалагдаж, хэдэн хүний хүртээл болох вэ гэдэг нь маш томоохон цогц асуудал шүү дээ. Яг үнэндээ манай монголчууд хэлбэрийг нь хараад байдаг. Энд 38 сая төгрөгийн эд зүйл малтуулж байсны оронд эмнэлэгт нэг машин өгчихье гээд байдаг. Тэр машин хоёр жилийн дараа л байхгүй болно. Гэтэл түүхэн дурсгалууд хадгалагдаж л байна. Монголчууд бид ямар түүх, соёлтой ард түмэн байсан бэ гэдгийг тэр гүнд байсан зүйлээр л нотлоно шүү дээ.

**-Орхон аймгийн музей хэчнээн танхимтай, хэчнээн үзмэртэй, хэдэн хүнд үйлчлэх хүчин чадалтай вэ?**

-Орхон аймгийн музей 1983 оны арваннэгдүгээр сарын 23-нд байгуулагдсан. Эдүгээ 34 дэх жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна. Таван танхимтай, 1600гаруйүзмэртэй. Тэдгээрийн 60 орчим хувь нь дэлгэгдсэн. 40 орчим хувь нь сан хөмрөгтөө хадгалагдаж байдаг. Хүчин чадлын хувьд Эрдэнэтийн 100 мянган хүн ам, мөн дайран өнгөрч байгаа болон зочлон ирсэн хүн бүхэнд үйлчилдэг. Одоогийн байдлаар 40 жилийн өмнө баригдсан барилгад үйл ажиллагаагаа явуулж байна. Музейн шинэ барилга баригдах асуудал төвшин төвшиндөө яригдаж л байгаа.

**-Аймгийн музей орон нутгийн аялал жуулчлалын бодлоготой хэрхэн уялддаг юм бол?**

-Аймгийн аялал жуулчлалын газартай мэдээлэл өгөх төвшинд хамтарч ажилладаг. Хот доторх хөшөө дурсгалуудаа судалсан. Бусдын хүртээл болоход энэ ийм учиртай, ийм түүхтэй, онцлогтой дурсгал шүү гэх мэтээр хүмүүст тайлбарлах, мэдээлэл өгөх журмаар хамтарч ажиллаж байна. Хөтөчтэй аялал гэсэн үг. Хүмүүс хөшөөг хараад өндөрлөг юм гэж ойлгохоос бус энэ хөшөө дурсгалыг яах гэж хийсэн юм, ямар онцлогтой газар хийсэн бэ, ямар учиртай вэ гэдгийг нь тэр бүр мэддэггүй. Манайд жил бүрийн есдүгээр сард аялал жуулчлалын өдрийг зохион байгуулдаг. Энэ өдөр орон нутгийн иргэд, сургуулийн сурагчдыг хот доторх хөшөө дурсгалуудтай танилцуулж, мэдээ мэдээлэл өгдөг юм.

**-Хотын дотор хэчнээн хөшөө дурсгал байдаг вэ. Орон нутгаас музейн сан хөмрөгийг баяжуулах, нэмэгдүүлэх тал дээр тусалдаг уу?**

-22 хөшөө дурсгал бий. Аймгийн ИТХ-аар батлуулаад гаргасан байгаа. Би нэг зүйлд маш их баярладаг юм. Манай аймгийн удирдлагууд музейн 1600 гаруй үзмэрийн тоог нэмэхэд маш их туслаж, дэмждэг. Сэтгэл байна гэдэг чинь болж байгаа байхгүй юу.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

# Ж.НАРАНТУЯА: Монгол туургатны 28 үндэстэн ястны 5000 гаруй хүний учиг шингэсэн

Б.ДАВААХҮҮ

Монголын нууц товчоог 108 метр эсгий зээгт ширмэлээр урласан дүрслэх урлагийн бүтээлийг олон нийтэд танилцуулах ёслол Сүхбаатарын талбайд боллоо. Энэхүү бүтээлийг Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын "Хан Хэнтийн гар урчууд" ХХК-ийн хамт олон санаачлан эхлүүлсэн бөгөөд Өвөрмонгол, Тува, Буриад, Халимаг, Киргиз зэрэг монгол туургатнууд ур шингээн оролцжээ. Уг бүтээлд 108 метр цагаан эсгий, 2000 км зээг, 20000 км метр тэмээний утас, 120 ширхэг тэвнэ, 120 ширхэг зүү, 32 өнгийн 100 гаруй литр будаг, 288 метр нягтруулагч таар, 110 метр цагаан даавуу орсон байна. Монгол туургатны уламжлалт гар урлалын нэг төрөл болох зээгт эсгий ширмэлийг хойч үедээ залгамжлуулан үлдээх зорилготойгоор Чингис хааны үеийн ахуй амьдрал, ёс заншлыг энэхүү бүтээлд шигтгэж өгчээ. Мөн Монгол зураг, Монгол үндэсний хээ угалз, Хүннүгийн үеийн буган хөшөө, хадны сүг зураг, монгол ёс заншил болох нүүдлэх, мал маллах, бөөгийн үйл, уран дарханы үйл болон бусад үйл явцыг багтаан харуулснаараа онцлог болсон байна. Гиннест бүртгүүлэх зорилготой эл дүрслэх урлагийн бүтээлийг танилцуулах ёслолд Ерөнхийлөгчийн Соёл, шашны бодлогын зөвлөх Ц.Хулан, Батлан хамгаалахын сайд Б.Бат-Эрдэнэ,УИХ-ын гишүүн Л.Оюун-Эрдэнэ, Нийслэлийн соёл, урлагийн газрын дарга Ж.Дамдинцэрэн нарын албаны эрхмүүд "Хан Хэнтийн гар урчууд" ХХК-ийн хамт олон хийгээд уг бүтээлийг урлахад гар бие оролцсон Монгол туургатнууд хүрэлцэн ирж баярласан юм. Энэ үеэр Нууц товчоог эсгий зээгт ширмэлээр урлах ажлыг санаачилсан Д.Нэргүй, Ж.Нарантуяа нарын гэр бүлийг Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнав. Хийсэн бүтээснээ төр, засгаар үнэлүүлж, СТА гэх хүндтэй цол тэмдгийг гардан авсных нь дараа "Хан Хэнтийн гар урчууд" ХХК-ийн захирал Ж.Нарантуяатай цөөн хором ярилцлаа.



**-Монголын нууц товчоог 108 метр эсгий зээгт ширмэлээр урлах ажлыг санаачлан хэрэгжүүлснийг тань төр, засгаас үнэлж, Соёлын тэргүүний ажилтан гэсэн цол тэмдгээр шагналаа. Юун түрүүнд танд баяр хүргэе?**

- Баярлалаа. Танай сониныг уншин суугаа Монгол туургатан, монголчууддаа өнөөдрийг баярт өдрийн мэндийг хүргэе. Нөхрийнхөө хамт энэхүү дүрслэх урлагийн бүтээлийг санаачлан хийж, бас тэр нөр их хөдөлмөрөө үнэлүүлж, СТА гэсэн тэмдгээр шагнуулсандаа туйлын их баяртай байна.

**-Бүтээлийнхээ гол онцлогийг дурьдахгүй юу. Хэчнээн хүн оролцсон бэ?**

-Маш олон хүний учиг шингэсэн гэдгээрээ онцлог. Монгол туургатны 28 үндэстэн ястны 5000 гаруй хүний учиг шингээсэн бүтээл болж боссон. Чингис хаан төрснөөс хойш эхлээд насан өөд болох хүртэлх дүрслэлүүд орсон байгаа. Дээд, доод эмжээрт нь хадны сүг зураг, монгол хээ угалз, Хүннүгийн үеийн буган хөшөө зэргийг багтаан урласан.

**-Санаа анх яаж төрсөн бэ?**

-Хэнтий аймагт аялал жуулчлалыг хөгжүүлэх үйлсэд иргэн бүр идэвхтэй оролцох ёстой гэсэн Засаг даргын захирамж гарсан юм. Тэр үед нөхөртэйгөө ярилцаж байгаад Монголын нууц товчоогоо урлахаар шийдсэн.

**-Яагаад эсгий дээр урлах болов?**

-Бид Монголынхоо нууц товчоог урлахын өмнө эхлээд цаасан дээр урлах уу, эсвэл даавуу нь дээр үү гэх мэтээр судалж үзсэн юм. Ингэхэд Гиннест даавуу болон цаасан дээр урласан бүтээл байдаг юм билээ. Харин эсгийнд урласан бүтээл огт байхгүй байсан. Тэгээд л эсгийг сонгож, нууц товчоогоо урлахаар шийдсэн хэрэг. Эхэндээ бид 100 метр эсгий дээр урласан юм. Харин дараа нь Баялаг бүтээгчдийн холбооны Ерөнхийлөгчтэй ярилцаж байгаад Монгол бэлгэдлээ бодож, 108 метр болгосон.

**-Зургийг нь хэн зурсан бэ?**

-Манай гэр бүлийн хүн зурсан. Монголынхоо нууц товчоог уншаад, өөрөө дүрслээд зурсан. Нөхөр маань удам дамжсан зураач хүн.

**-Бүтээлийг урлах ажлаа монгол туургатнуудаа сурталчлах, тэдний учгийг шингээхэд баялаг бүтээгчдийг дэмжих холбоо тусалсан гэсэн. Энэ тухайд?**

-Тэгэлгүй яах вэ, нөхөр бид хоёрыг 21 аймгаар явахад манай баялаг бүтээгчид маань л хадаг сүүгээ бариад угтаж байсан. Энэ дашрамд, Монголынхоо бүх баялаг бүтээгчдэд баярлалаа гэж хэлье. Та нарынхаа хүч, хөдөлмөрөөр л энэ том бүтээлийн ард гарлаа. Одоо цаг үе өөр болжээ. Фэйсбүүк, "we chat" гэх мэт нийгмийн сүлжээг ашиглаж, баялаг бүтээгчдийн холбоогоороо дамжуулан монгол туургатнаа нэгтгэн, тэднийхээ учгийг шингээж бүтээлээ дуусгасан.

**-Хэдий хэр хугацаа зарцуулсан бэ?**

-2015 оны арванхоёрдугаар сарын 28-нд эхлээд 2017 оны гуравдугаар сарын 12-нд сүүлийн учгаа шингээгээд дууссан. Зээглэн ширэх оёдол эдүгээ бараг мартагдсан учраас одоо сэргээж, хойч үедээ залгамжлуулан өвлүүлэхээр ажиллаж байна. Би өөрөө зээгт оёдлыг гурван үе дамжин өвлөж авсан. Бүтээлээ урлах явцдаа 4000 гаруй хүнд зээглэн ширэх оёдлоо зааж сургасандаа маш их баяртай байгаа.

**-Монголын нууц товчоог урлахад хэдэн насны хүмүүс оролцсон бэ. Манай уншигчдад сонирхуулаач?**

-Хамгийн бага нь гурван настай хүүхэд. Хамгийн хөгшин нь 96 настай хүн байсан.

**-Эсгийнд урласан Монголын нууц товчоо цаашид хаана байрлах вэ?**

-Хэнтий аймгийн хүндэтгэлийн хаалганы ойролцоох долоон га газрыг аймгийн Засаг дарга Н.Ганбямба энэхүү эсгий бүтээлд зориулан шийдэж өгсөн. Тэнд 24 ханатай модон гэр барьж, эсгий урлалаа хадгална. Хан Хэнтий нутгийг зорин ирсэн аялагчид, жуулчид тус гэрээр зочилж, бүтээлийг маань сонирхох боломжтой.



*Гэрэл зургийг П.НАРАНДЭЛГЭР*

ХҮЧИНГҮЙД ТООЦОВ

Дизайнер оёдолчин ажилд яаралтай авна.
**Утас: 91035335, 99180574**

# ЗАВСАРЛАГА

Улаанбаатарт:

Маргааш

Өдөр +14
Шөнө +8

Нөгөөдөр

Өдөр +16
Шөнө +4

Өдрийн зурхай

**НАМРЫН ТЭРГҮҮН ШАР БИЧ САРЫН ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ ХӨХ ЛУУ ӨДӨР**

**Үс засуулбал:** *Өвчин эмгэг ирнэ.*

**Наран ургах, шингэх:** *06.35-19.07*



Тухайн өдөр хулгана, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба угаал үйлдэх, бороо хур оруулах, зэтгэрийг номхотгох, хөгжмийн зэмсэг урлах, дарханы үйлд сайн. Гүүр тавих, газар шороо ухахад муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

Books "Ном" буланд тавтай морил

# ИХ ГЭРИЙН ЭЗЭГТЭЙ

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь №154 дугаарт**

Салхи ширүүсч байлаа. Жеми үлдсэн зайг багцаалж үзээд дарвуулаа буулгасан ч долгион салыг нь эрэгт урсган аваачих юм байна гэж тооцоолов. Тэгээд дарвуулаа даруй буулгалаа. Гэтэл хурд саарсангүй. Сал одоо долгионы эрхэнд бүрэн ороод нэгэнтээ долгионы хяр дээр гарч, нэгэнтээ доош унаж байв. Банда, Жеми хоёр усанд унахгүйн тулд салнаас хоёр гараараа тас зуурлаа. "Эрэгт буух хэцүү байх болно" гэж Жеми мэдэж байсан боловч байгалийн догшин салхитай тааралдах юм гэж санасангүй. Хад чулуу бүр ойрхон болсон байлаа. Их долгион эрчээрээ хад мөргөн дээшээ усан оргилуур болон цацарч байгаа харагдана. Төлөвлөгөө бүтэх эсэх нь салаа хадгалан хамгаалж чадах эсэхээс болно. Салгүй бол буцаж чадахгүй. Салгүй бол өөрсдийгөө үхсэнд тооцож болно. Байгалийн догшин хүч тэднийг шулуухан хад чулуу руу авч явлаа. Салхины шуугиан чих дөжрөм их. Асар том долгион гэнэт салыг нь шүүрэн авч очлоо.

-Сайн бариарай, Банда. Одоо эхэллээ... гэж Жеми хашгирав.

Лут их долгион салыг нь шүдэнзний мод аятай урсган хад чулуун дээгүүр хөврүүлнэ. Жеми, Банда хоёр салнаас байдаг чадлаараа зууран амь мэнд гарахын төлөө тэмцэв. Жеми доош харвал мод чулууны шовх үзүүр хутганы ир шиг сэрийнэ. Дахиад л хэдэн хором өнгөрвөл тэр хоёр эрэг дээр эсэн мэнд гарч, айх аюулгүй болно. Яг энэ агшинд сал огцомхон татасхийн нэг торх нь хадны сэрвэнд тээглэв. Тээглэсэн торх тэр даруй тэнгис рүү урсан одлоо. Сал далжийн хэдэн хормын дараа дахиад л нэг торх салж унав. Дараа нь дахиад нэг... Ширүүн салхи, хайр найргүй долгион, аюулт хад чулуу салыг тал тал тийш нь чулуудан тоглох ажээ. Салны дэвсгэр хөл доогуур нь гулсаж байгааг Жеми мэдэн Банда руу

-Үсэр... гэж хашгирав.

Өөрөө усанд умбан орсонд лут их долгион түүнийг шүүрэн авч, оньсон харвуул мэт эрэг рүү хүчтэй шидэв. Жеми яаж ч чадсангүй.



Уушги нь хорсож, нүдниих нь өмнө өнгө бүрийн гал жирвэлзэхийг мэдэрлээ. "Би живж байна" гэж бодтол энэхэн агшинд долгион түүнийг элсэн эрэг дээр хаях нь тэр. Цээж хөл нь шалбаран хувцас нь юу ч үгүй урагджээ. Арайхийж өндийж суугаад Бандаг эрж ийш тийшээ харав. Банда Жемигээс арваад ярдын зайд элсэн дээгүүр мөлхөж байлаа. Африк эр тэнгисийн усаар бөөлжиж харагдав. Жеми босож, дэргэд нь салгалж очоод,

-Чи зүгээр үү? гэсэнд Банда толгой дохиод нэгэнтээ хий сорон амьсгаа авч, Жемийн өөдөөс харж,

-Би харж чаддаггүй... гэв. Жеми түүнийг түшин босгов. Хоёр эр хад чулууны зүг харвал салнаас нь юу ч харагдсангүй. Галзуу догшин тэнгис муу салыг нь зомгол болтол хэмхчжээ.

Тэр хоёр алмасын уурхайд хүрч ирлээ. Гэвч даанч буцах замгүй болжээ. Ард нь тэнгис далай догшрон ганихарч байв. Өмнө нь тэнгисийн хөвөөнөөс алсын уулсыг хүртэл үргэлжилсэн туулж баршгүй их цөл цэлийнэ. Хоорондуур нь ангал, хавцал хэрчсэн уулсын шовх оройг сарны бүдэг цайвар гэрэл гийгүүлнэ. Уулсын хормойд "Хек сенкессель" буюу Шулмасын тогоо хэмээх хөндийгөөр ямагт хүчит салхи зугаална. Энэ бол ертөнцийг бүтээсэн цагаас хойш анх байсан хэвээрээ байгаа онгон зэрлэг байгаль. Энд хүн байдгийг мэдэж болох ганц тэмдэг гэвэл "Хориотой бүс" гэж муруй хазгай бичсэн пайз байлаа. Тэдэнд далайгаар буцах зам хаалттай. Намиб цөлийг туулах ганц зам үлджээ.

-Заяа тавиландаа даатгаад энэ цөлийг туулах болж дээ... гэж Жеми хэлэхэд Банда толгой сэгсрээд,

-Харуул манааныхан биднийг харахтайгаа зэрэг алж орхино. Эсвэл модноос дүүжилнэ. Бид харуул манааныхан, галзуу нохдоос зугтаж зайлж чаддаг юм гэхэд минатай талбайгаар гарч чадахгүй. Бид нэгэнт өнгөрсөн гэж бодож байна... гэжээ.

Жеми Бандаг хараад харамсан гэмших сэтгэл төрөв. Жеми энэ африк эрийг ийм адал балмад явдалд татан оруулсан. Тэглээ гэж энэ негр хархүү түүнийг нэг ч удаа зэмлээгүй. Одоо ч гэсэн гарах арга замгүй болсныг мэдсээр байж. Банда Жемийг огтоос зэмлэн буруушаахгүй байна. Эргийг аймшигтай их нүжигнэн нүргэлэн мөргөж буй асар их долгионыг Жеми хараад гагцхүү ид шидийн гайхамшигаар амьд гарчээ гэж бодов. Шөнийн 02:00 цаг болжээ. Үүр цайтал, энэ хоёрыг илрүүлэн мэдэх хүртэл дөрвөн цаг үлджээ. Юутай ч одоохондоо амьд байж байна. "Бууж өгдөг юм бол чөтгөр намайг алгадаасай билээ" гэж Жеми бодов.

-Ажилдаа орцгооё, Банда... гэсэнд негр хархүү өөдөөс нь гайхан харж,

-Бас ямар ажил вэ?

-Бид энд алмас авах гэж ирсэн биз дээ, тийм үү? Тэгэхээр алмас цуглуулцгаая...

Банда энэ солиотой нүдтэй хачин эрийг гайхан ширтэв. Нойтон буурал үс нь толгойдоо наалдаад өмдний оронд салбайж, навсайсан юм санжигнаж байлаа.

-Чи юу хэлнэ вэ?

-Биднийг харахтай зэрэг буудаж ална гэж чи хэлсэн. Тэгэхээр баяжаад юм уу, ядуу хэвээрээ алагдахын ялгаа нь юу вэ? Бид ид шидээр энд хүрч ирлээ. Бас ид шидийн хүчээр эндээс гарч чадах нь юу магад. Хэрэв гарч чадах юм бол, чөтгөр алгад гар хоосон явмааргүй байна.

-Чи солиотой хүн юм гэж Банда аяархан хэлэв.

-Эс тийм бол чи бид хоёр энд зогсож байхгүйсэн гэж Жемийг сануулахад Банда дал мөрөө хавчаад,

-Татгалзах юм алга. Биднийг илрүүлж олтол өөр хийх ажил ч алга гэхэд Жеми урагдсан цамцаа тайлав. Банда ч бас түүнийг дуурайв.

-За тэгээд чиний яриад байдаг том том алмас эрдэнэ хаана байна вэ?

-Газар сайгүй бий. Харуул манааныхан галзуу нохой ч газар сайгүй.

-Одоохондоо бид тэр тухай санаа зовох юм алга. Харуулынхан хаялгын хавиар хэдийд эргүүл хийж эхэлдэг вэ?

-Үүр цайхаар...

Жеми жаахан бодолхийлээд,

-Тэдний очдоггүй, бидний нуугдчихаж болмоор тийм хэсэг бий юу?

-Тэд нэг ч газар үлдээлгүй эргэдэг. Бидэнд нуугдах газар байхгүй... гэхэд нь Жеми Бандагийн дал мөрөн дээр падхийтэл алгадаад,

-За тэгвэл ажилдаа орцгооё... гэжээ.

Банда элсэн дээгүүр мөлхөж, хуруугаараа элс тэмтэрч байгааг Жеми харав. Хоёр минут болоогүй байтал өндийж, Жемид гараа сарвайн,

-Оллоо... гэв.

Жеми бас мөлхөж элсийг хурууныхаа завсраар шүүж эхлэв. Түүний олсон эхний хоёр алмас жижгэвтэр байв. Гурав дахь нь дор хаяад 15 крат хүрхээр байв. Жеми дороо суугаад тэр чулууг удаан харав. Бүхэл бүтэн өв хөрөнгийг ийм амархан олж болно гэж итгэмээргүй. Энэ бүхэн Ван Дер Мерве түүний хамжаа түнш хоёрынх шүү дээ. Жеми цаашаа мөлхөв. Жеми, Банда хоёр гурван цагийн дотор 2-40 кратын 40 гаруй алмас оллоо. Тэнгэр дорно зүгээс гэгээрч эхлэв. Жеми чухам энэ үед эрлээ зогсоож, сал дээрээ харайж гараад эрэг хавийн хад чулуун дээгүүр хөвөн буцах замдаа орохоор төлөвлөж байсан билээ. Одоо тэр тухай бодохын ч хэрэг алга.

-Удахгүй үүр цайна. Дахиад эрье... гэж Жемийг хэлэхэд,

-Олсноо ашиглаж чадахгүй шүү дээ, чи. Нэгийг нь ч... Эсвэл чи баян хүн болж үхэх дуртай байна уу?

-Одоохондоо үхэх огт хүсэлгүй байна.

Тэд хоёул эрлээ үргэлжлүүлэн ямар нэг санаа бодолгүйгээр алмас түүсээр байв. Ухаан нь балартаж солиороо юу гэлтэй. Нэн удалгүй тэдний уранхай цамцан дээр 60 орчим алмас орсон байлаа.

-Бүгдийг нь би бариад явах уу? Банда асуухад,

-Үгүй. Хоёулаа... гэж Жеми хэлснээ Бандагийн юу хэлэх гэснийг гэнэт ойлгов. Алмас авч яваад баригдсан хүнийг их удаан тамлан алдаг.

-Би аваад явья гэж Жеми хэлээд алмасыг боож бүсэндээ уяв. Тэнгэрийн хаяа цайвар бор болов. Одоо удахгүй нар мандана. "Одоо яах вэ, гэдэг асуулт байна. Энэ асуултад юу гэж хариулах вэ". Хоёул эндээ үлдээд үхэж болох эсвэл элсэн цөл рүү яваад үхсэн ч болно.

-Явцгаая... гээд Жеми, Банда хоёр цөлийн зүг алгуурхан явлаа.

-Минатай талбай хаанаас эхэлдэг вэ?

-Эндээс зуугаад ярдын газраас эхэлнэ.

Алсад нохой хуцах чимээ сонсдов.

-Бид минад сэтгэл зовсны хэрэггүй биз дээ. Нохой наашаа ирж явна. Харуул манааныхан эргүүлд гарчээ.

-Тэд хэдийд энд ирэх вэ?

-15 минут орчимын дараа. 10 минутын дараа ч байж магад.

Бараг гэгээ оржээ. Урьд бүдэгхэн сүүдэр шиг харагдаж байсан юм одоо бага шиг элсэн довцог алсын уулс болж хувирлаа. Нуугдах газар даанч алга даа.

**Үргэлжлэл дараагийн дугаарт...**


